

## **Гарчиг**

### **БҮЛЭГ I**

ӨРГӨДЛИЙГ ЯАЖ ЗӨВ БӨГЛӨХ ТАЛААР .....	5
---------------------------------------	---

### **БҮЛЭГ II**

ЕРӨНХИЙ МЭДЭГДЭЛ .....	6
2.1 ХУУЛИЙН ҮНДЭСЛЭЛ.....	6
2.2 ГАДААДЫН ИРГЭД ПОЛЬШ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭР ДЭЭР ОРШИН СУУХ НӨХЦӨЛ.....	6
2.3 МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАР, ӨРГӨДӨЛ, БИЧИГ БАРИМТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА .....	7
2.4 АСУУДАЛ ШИЙДЭГДЭХ ХУГАЦАА .....	7
2.5 ИТГЭМЖЛЭЛ.....	8
2.6 ЗАХИДАЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ.....	8
2.7 ГАДААД ЯВСАН ҮЕД ЗАХИДАЛ ХҮЛЭЭН АВАХ .....	10
2.8 ХУГАЦААГ БАРИМТЛАХ ШААРДЛАГА .....	10
2.9 ХЭРГИЙН ЯВЦТАЙ ТАНИЛЦАХ.....	11
2.10 ТЭМДЭГТИЙН ХУРААМЖ.....	11

### **БҮЛЭГ III**

ВИЗ СУНГАХ.....	12
3.1 ӨРГӨДЛИЙГ АВЧ ХЭЛЭЛЦЭХ БАЙГУУЛЛАГА .....	12
3.2 ОРОН НУТГИЙН ВИЗИЙГ СУНГАХ .....	12
3.3 ШЕНГЕНИЙ ВИЗИЙГ СУНГАХ .....	13
3.4 ӨРГӨДЛИЙГ ГАРГАХ ХУГАЦАА .....	13
3.5 АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ .....	14

3.6 БИЧИГ БАРИМТУУД.....	14
--------------------------	----

## **БҮЛЭГ IV**

ТҮР ХУГАЦААНД ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ.....	15
4.1 ТҮР ХУГАЦААНД ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮНДЭСЛЭЛҮҮД.....	15
4.2 ПОЛЬШ УЛСАД ХУУЛЬ БУСААР АМЬДРЧ БАЙГАА ТОХИОЛДОЛД ТҮР ХУГАЦААГААР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ .....	19
4.3 ӨРГӨДӨЛД ХАМААТАЙ НЭМЭЛТ ШААРДЛАГУУД .....	19
4.4 ӨРГӨДЛИЙГ АВЧ ХЭЛЭЛЦЭГЧ БАЙГУУЛЛАГА .....	20
4.5 БИЧИГ БАРИМТУУД.....	20
4.6 ГЭР БҮЛИЙН ГИШҮҮН .....	22
4.7 ТҮР ХУГАЦААГААР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ ХУГАЦАА .....	22
4.8 ӨРГӨДЛИЙГ ХАРГАЛЗАЖ ҮЗЭХГҮЙ ШАЛТГААН .....	23
4.9 ТҮР ХУГАЦААГААР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ24	
4.10 ТҮР ХУГАЦААГААР АМЬДРАХ ЗӨВШӨӨРЛИЙГ БУЦААН ТАТАЖ АВАХ .....	25
4.11 ГАДААДАД БАЙГАА НӨХЦӨЛД ТҮР ХУГАЦААГААР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ХӨӨЦӨЛДӨХ.....	25

## **БҮЛЭГ V**

БАЙНГА ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ.....	26
5.1 ШИЙДВЭР ГАРГАГЧ БАЙГУЛЛАГА .....	26
5.2 ТАСРАЛТГҮЙ АМЬДАРСАН БАЙХ ШААРДЛАГА – ЗӨВТГӨХ ШАЛТГААНТАЙ ЗАСВАРЛАГААНУУД .....	26
5.3 БИЧИГ БАРИМТУУД.....	27
5.4 ӨРГӨДӨЛД ХАМААРАЛТАЙ НЭМЭЛТ ШААРДЛАГУУД.....	27
5.5 ӨРГӨДЛИЙГ ХАРГАЛЗАЖ ҮЗЭХГҮЙ ШАЛТГААН .....	28
5.6 БАЙНГА ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ.....	28

5.7 БАЙНГА ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙГ БУЦААЖ ТАТАН АВАХ.....29

5.8 БАЙНГА ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ ХУГАЦАА.....29

## **БҮЛЭГ VI**

ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСАД УДААН ХУГАЦААГААР АМЬДРАХ ЗӨВШӨӨРӨЛ...29

6.1 ШИЙДВЭР ГАРГАГЧ БАЙГУУЛЛАГА .....30

6.2 БИЧИГ БАРИМТУУД.....30

6.3 ӨРГӨДӨЛД ХАМААРАЛТАЙ НЭМЭЛТ ШААРДЛАГУУД.....30

6.4 ӨРГӨДЛИЙГ ХАРГАЛЗАЖ ҮЗЭХГҮЙ ШАЛТГААН .....31

6.5 ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСАД УДААН ХУГАЦААГААР АМЬДРАХ  
ЗӨВШӨӨРӨЛ АВАХ БОЛОМЖГҮЙ ХҮМҮҮС .....32

6.6 ХУУЛЬ ЁСООР ТАСРАЛТГҮЙ 5 ЖИЛ ОРШИН СУУХ ШААРДЛАГА.....32

6.7 ТАСРАЛТГҮЙ ОРШИН СУУХ ШААРДЛАГА- ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН  
ЗАВСАРУУД .....33

6.8 ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСАД УДААН ХУГАЦААГААР АМЬДРАХ  
ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ.....33

6.9 ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСАД УДААН ХУГАЦААГААР АМЬДРАХ  
ЗӨВШӨӨРЛИЙГ БУЦААН ТАТАЖ АВАХ.....33

6.10 ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСАД УДААН ХУГАЦААГААР АМЬДРАХ  
ЗӨВШӨӨРЛИЙГ ДАХИН ОЛЖ АВАХ .....34

6.11 ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСАД УДААН ХУГАЦААГААР АМЬДРАХ  
ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ ХУГАЦАА .....34

## **БҮЛЭГ VII**

ОРШИН СУУХ ЭРХИЙН КАРТ .....34

7.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....34

7.2 ОРШИН СУУХ ЭРХИЙН КАРТИЙГ СОЛИХ .....35

7.3 ОРШИН СУУХ ЭРХИЙН КАРТИЙГ СОЛЪЖ ӨГӨХ БАЙГУУЛЛАГА.....35

7.4 ОРШИН СУУХ ЭРХИЙН КАРТИЙГ ГЭЭЖ ҮРЭГДҮҮЛЭХ.....36

7.5 ОРШИН СУУХ ЭРХИЙН КАРТИЙГ АШИГЛАН АЯЛАН ЖУУЛЧЛАХ .....36

## **БҮЛЭГ VIII**

ДАВЖ ЗААЛДАХ ҮЙЛ ЯВЦ.....36

8.1 ЗААСАН ХУГАЦАА БАГАДАХ .....37

8.2 ХАВТАСТ ХЭРЭГТЭЙ ТАНИЛЦАХ .....37

8.3 МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАР, ӨРГӨДӨЛ, БИЧИГ БАРИМТЫГ ТУШААХ НЬ .....37

8.4 САНАЛ ГОМДОЛ ..... 38

## БҮЛЭГ I

### ӨРГӨДЛИЙГ ЯАЖ ЗӨВ БӨГЛӨХ ТАЛААР

Оршин суух зөвшөөрлийн өргөдлийг бөглөхдөө дараах зүйлсийг анхаарна уу.

- ▲ **польш хэл дээр гаргацтай бөглөх;**
- ▲ **өргөдлийн хүснэгт болгоныг үнэн бодитоор бөглөх;**
- ▲ нүх болгоныг том үсгээр бөглөх;
- ▲ хэрэв урьд өмнө нь **өөр нэр овогтой байсан бол** –тайлбар хэсэгт тэр талаар тодруулах;
- ▲ **амьдарч байгаа газрынхаа хаягийг үнэн бодитоор бичих** ( ямар хаягаар захидал хүлээн авах);
- ▲ ял шийтгэлийн хэсэгт **оногдсон ял шийтгэл болон шийдэгдэх шатанд байгаа ял шийтгэл болон хэрэг зөрчлөө бичих;**
- ▲ ял шийтгэл оноосон шийдвэр гарсан эсэхэд эргэлзээтэй байгаа нөхцөлд явцын дунд байгааг мэдүүлэх (**АНХААР: торгууль төлөх ёстой** шийдвэр нь хуулийн арга хэмжээ авагдаж шийтгэл оногдсоныг илтгэнэ);
- ▲ **тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг** өргөдөлд хавсаргах;
- ▲ өргөдөлд **тохирох хэмжээний дагуу авахуулсан цээж зургийг** хавсаргах;
- ▲ **овог нэрээ латин үсгээр бичиж өөрийн биеэр гарын үсгээ зурах;**
- ▲ (гадаадын иргэдийн тухай хуулийн **1-р заалтын 53-р бүлэгийн 7-д** заасанчлан) гэр бүлтэйгээ нэгдэх зорилгоор түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл хөөцөлдөж байгаа тохиолдолд **Польш улсын нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа гадаадын иргэн гарын үсэг зурах ёстой** боловч хэрэв бага насны хүүхэд хөөцөлдөж байгаа бол эцэг эхийн асрамж үзүүлэгч бүх хүн зөвшөөрөл гаргах шаардлагатай.
- ▲ **хүчинтэй аялалын бичиг баримтаа** харуулах. Онцгой шалтгаанаар хэрэв гадаадын иргэн аялалын бичиг баримт **байхгүй бөгөөд олж авах боломжгүй нөхцөлд биеийн байцаалтыг нь нотлох өөр бичиг баримт үзүүлж болно;**
- ▲ өргөдөлд тусгагдсан мэдээллүүдийг нотлох, асуудлыг хурдан шийдвэрлэхэд туслах баримт болгоныг хавсаргах;

★ эргэлзээтэй зүйл байвал – мужийн захиргааны ажилтанаас тусламж хүсэх.

## БҮЛЭГ II

### ЕРӨНХИЙ МЭДЭГДЭЛ

#### 2.1 ХУУЛИЙН ҮНДЭСЛЭЛ

- ▲ Гадаадын иргэдийн талаархи 2003 оны 6 сарын 13-ны хууль (2006 оны хуулийн 234-р дугаар, 1694-р заалт, сэдэлд өөрчилсөн)
- ▲ 1960 оны 6 сарын 14-нд гарсан Захиргааны хариуцлагын тухай хууль (2000 оны хуулийн 98-р дугаар, 1017-р заалт, сүүлд өөрчлөгдсөн)
- ▲ Виза-ны Хууль дүрэмийг тогтоосон 2009 оны 7 сарын 13-ны өдөр батлагдсан 810/2009 дугаарын Европын Парламентын ба Удирдлагын батламж (2008 оны 9 сарын 15-ны Л 243 Европын Холбооны хуулийн эмхэтгэл)

#### 2.2 ГАДААДЫН ИРГЭД ПОЛЬШ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭР ДЭЭР ОРШИН СУУХ НӨХЦӨЛ

##### Гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр байхад дараахи бичиг баримттай байх шаардлагатай:

- 1) хүчинтэй аялалын бичиг баримттай байх;
- 2) газар нутагт нь орж ирэх ба амьдрах эрх олгох хүчинтэй визтэй эсвэл шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөр чухал бичиг баримттай байх;
- 3) дайрч өнгөрөхөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөр улсад амьдрах ба орж ирэх зөвшөөрөлтэй байх зэрэг болно.

Гадаадын иргэн **Польшид олгосон оршин суух эрхийн карт** болон Шенгений бүсийн аль нэг оронд олгосон орон нутагийн виза эсвэл оршин суух зөвшөөрлийн үндэслэлээр Шенгений бүсийн орнуудаар (мөн Польш улсын нутаг дэвсгэр дээр) 6 сарын дотор 3 сарын хугацааг хэтрүүлэлгүйгээр заавал виз авах шаардлагагүйгээр аялан жуулчилж болно. Ингэхдээ Шенгений бусад орнуудад нэвтрэх ба амьдрах ерөнхий зарчмыг дагах хэрэгтэй. Үүнд:

- ▲ хүчинтэй аялалын бичиг баримттай байх,
- ▲ байх хугацааныхаа нөхцөл, зорилгыг тайлбарлах чадвартай байх,
- ▲ амьдрах хугацаандаа хэрэглэхэд хангалттай санхүүгийн боломжтой, эсвэл хууль ёсоор мөнгө олох боломжтой байх,

- ▲ нийтийн аюулгүй байдал, дотоодын хамгаалал, нийтийн эрүүл мэнд эсвэл гишүүн орнуудын олон улсын харилцаанд аюул учруулахаар хүнд тооцогдоогүй байх, ялангуяа гишүүн орнуудын аль нэг оронд орох эрхээ хаалгаагүй байх гэх зэрэг болно.

**Шенгений бүсийн орнуудад:** Австри, Белги, Дани, Финланд, Франц, Грек, Испани, Люксембург, Нидерланд, Герман, Португали, Швед, Итали, Естони, Литв, Латив, Малта, Польш, Словак, Словен, Унгар болон Норвег, Исланд ба Швейцарь орно.(сүүлийн 3 орон Европын Холбооны улс биш ч Шенгений бүсэд хамрагддаг)

**Их Британи, Ирланд, Ципр, Болгар болон Румуни зэрэг орон Европын Холбооны улс ч Шенгений бүсийн орнуудад хамрагддаггүй анхаарна уу.**

### 2.3 МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАР, ӨРГӨДӨЛ, БИЧИГ БАРИМТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Гадаадын иргэний Польш улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суух асуудлаар гаргах өргөдөл, хүсэлт, бичиг баримтууд нь дараах шаардлагыг хангасан байх ёстой.

- ▲ **польш хэл дээр бичигдсэн байх;**
- ▲ **бичиг баримт эх хувиараа эсвэл албан ёсоор батлагдсан хуулбар нь;**
- ▲ эх хувийн оронд түүний хуулбар нь албан ёсоор нотариат болон тухайн хүний өмнөөс итгэмжлэгдсэн өмгөөлөгч, хуульч, патентын төлөөлөгч, татварын байцаагчаар баталгаажуулагдсан байвал хүчинтэйд тооцно – **биеийн байцаалтын (аялалын) бичиг баримт үүнд хамрагдахгүй**
- ▲ асуудлыг шийдэхэд нотолгоо болох баримтууд **гадаад хэл дээр байгаа бол польш хэл дээр тамгатай орчуулагчаар орчуулагдсан байх** (аялалын бичиг баримт үүнд хамрагдахгүй).

### 2.4 АСУУДАЛ ШИЙДЭГДЭХ ХУГАЦАА

**Хууль тогтоомжийн дагуу асуудал шийдэгдэхэд:**

- ▲ **тайлбар шаардлагатай асуудлын хугацаа нэг сараас хэтрэхгүйгээр,**
- ▲ **нилээн хүндрэлтэй асуудлын хугацаа – хэргийг нягталж үзсэн өдөрөөс 2 сарын хугацаа хэтрэхгүйгээр,**
- ▲ **давж заалдах үйл явцад – шийдвэрийг хүлээн авсанаас 1 сарын дотор.**

**Байнга оршин суух/ Европын Холбооны улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл өгөх асуудал – асуудлыг авч хэлэлцэж эхэлсэн өдөрөөс 3 сарын хугацааг хэтрэхгүйгээр дуусгавар болох ёстой,**



- ▲ **давж заалдах үйл явцад** – шийдвэрийг хүлээн авсанаас 2 сарын дотор дуусгавар болох ёстой.

**Түр хугацаагаар оршин суух/байнга оршин суух/ Европын Холбооны улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл өгөх шийдвэр гаргахаас өмнө тухайн мужийн захиргаа нь Хилийн цагдаагийн салбар газрын дарга, Мужийн Цагдаагийн хэлтэсийн дарга, Дотоодын Аюулгүй Байдлын Агентын дарга болон шаардлагатай гэж үзвэл бусад албан газруудад тухайн гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр орж ирэх ба амьдрах болсон нөхцөлд нийтийн дэг журам тайван байдалд аюул учруулж болзошгүй эсэхийг магадласан өргөдөл гаргах үүрэгтэй.**

Дээр дурдсан албан байгууллагууд хэрэгтэй мэдээллүүдийг 30 хүртэлх хоногийн дотор гаргаж өгөх үүрэгтэй тул **хэргийг шийдвэрлэх үйл явц 30 хоногоос хэтэрч болзошгүй.**

**Дурдсан хугацаанд шийдвэр гараагүй нөхцөлд анхан ба хоёр дахь шатны байгууллагууд өргөдөл гаргагч талд учир шалтгааныг мэдэгдэж шийдэгдэх хугацааг шинээр зааж өгөх үүрэгтэй.**

## **2.5 ИТГЭМЖЛЭЛ**

**Өргөдөл гаргагч тал заавал биечлэн үйлдэхээс бусад асуудалд итгэмжлэгч тогтоож болно.**

**Итгэмжлэгчээр эрх зүйн хариуцлага хүлээх чадвартай хувь хүнийг сонгоно.**

- ▲ итгэмжлэл нь **бичгээр хийгдсэн буюу протоколд тэмдэглэгдсэн байх ёстой.**
- ▲ **итгэмжлэгчээр тогтоогдсон бичигийн эх хувь эсвэл албан ёсоор баталгаажуулсан хуулбарыг** хавтаст бичигт хавсаргана.
- ▲ хэрэгт итгэмжлэгч тогтоогдсон бол **тэмдэгтийн хураамж болох 17 золот төлсөн төлбөрийн баримтыг хавсаргах;**
- ▲ **итгэмжлэгч нь гадаадын иргэнийг тухайн мужийн захиргаа болон Гадаад Иргэдийн Асуудал Хариуцсан Албаны Даргын өмнө тус тус төлөөлөх эрхтэй.**

## **2.6 ЗАХИДАЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ**

Шийдвэр, зарлан дуудлага, мэдэгдэл гэх зэрэг бичиг баримтууд гадаадын иргэнд **шуудангаар** очиход хүлээн авсан баримтанд гарын үсэг зурах ёстой ба өөрөөр анхан ба хоёр дахь шатны байгууллагуудын ажилтанаас гардан авч болно.

**Захидал нь өргөдөл гаргагчийн заасан хаягаар эсвэл түүний байж болох аливаа газар хүлээлгэн өгөгдөнө.** Мөн захидал бичгийг тухайн хүний ажлын газарт хүргэж өгөх боломжтой.

## **ХАЯГ ӨӨРЧЛӨГДӨХ**

Асуудал шийдвэрлэгдэх явцад талууд болон тэдний төлөөлөгчид, итгэмжлэгчдийн **хаягт өөрчлөлт орсон бол нийтийн захиргааны байгууллагад түүнийгээ заавал мэдэгдэх үүрэгтэй.** Захидал бичиг нь дээрхи хүмүүсийн хамгийн сүүлд өгсөн хаягаар илгээгдэнэ.

- ▲ **Дээр дурдсан нөхцөлийг биелүүлээгүй тохиолдолд захидлыг заасан хаягаар хүлээн авсан гэж үзнэ**
- ▲ **ЗАХИДАЛ ХҮЛЭЭН АВАХ ХҮН ЭЗГҮЙ БАЙХ** тохиолдолд захидлыг гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, хөрш эсвэл байрны сахиулд заавал тэр хүнд дамжуулна гэсэн нөхцөлд үлдээж болно. Эдгээр хүмүүс захидал хүлээн авсан баримтанд гарын үсгээ зурж баталгаажуулах бөгөөд энэ баримтыг шуудангийн хайрцагт, хэрэв байхгүй бол хаалган дээр үлдээсэн байна.

#### ЗАХИДАЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨНД ТООЦОХ

- ▲ Захидлыг өргөдөл гаргагчийн **хаягаар**, хэрэв төлөөлөгчөөр дамжуулж хөөцөлдөж байгаа бол түүний хаягаар явуулна.
  - **Өргөдөлд гаргагч нь захидал хүлээн авахдаа гарын үсгээ** он, сартай нь хамт **бичиж баталгаажуулах үүрэгтэй**. Хэрэв шуудангаар болон өөр хэлбэрээр ирсэн захидлыг хүлээн авч баталгаажуулахаас татгалзсан бол хүлээлгэж өгсөн тал өөрөө хэзээ, хэн, юуны учир захидлыг хүлээн авахаас татгалзсаныг тэмдэглэж, захиа нь тэдгээр тэмдэглэлтэйгээр илгээсэн газраа буцаж очино. Хүлээн авахаас татгалзсан тухайн өдөрт захидал өргөдөл гаргагчид хүргэгдсэнд тооцно.
  - **Хэрэв өргөдөл гаргагч тал шуудангаар болон өөр хэлбэрээр ирсэн захидлыг хүлээн авч баталгаажуулахаас татгалзсан бол**, захидал хүлээн авахыг татгалзсан он сар, татгалзсан гэсэн тэмдэглэлтэйгээр илгээсэн газраа буцаж очино. Энэ тохиолдолд бичиг баримтыг хүлээн авахаас татгалзсан тэр өдөрт хүлээн авсанд тооцно.
- ▲ **Итгэмжлэгчид** захидал хүргэгдэхдээ хэрэв өргөдөл гаргагч **хэд хэдэн** итгэмжлэгч тогтоосон бол тэдний дундаас нэгийг нь захидал хүлээн авах эрхтэйгээр сонгож тэр талаар асуудлыг хөтөлж байгаа байгууллагад мэдэгдэнэ. **Дээрхи нөхцлийг сахиагүй бол** захидал аль нэг итгэмжлэгчийн хаягаар хүргэгдэнэ.

#### ЗАХИДЛЫГ ДЭЭР ДУРДСАН АРГУУДААР ХҮРГЭХ БОЛОМЖГҮЙ НӨХЦӨЛД:

- ▲ захидал бичгийг шуудангаар явуулсан бол шуудангийн салбарт захиа 14 хоног хүртэлх хугацаанд хадгалагдана,
- ▲ албан байгууллагын ажилтанаас бичгийг гардаж авах байсан бол захидал 14 хоногийн турш тухайн албан байгууллагад хадгалагдана.

Захидлыг хүлээн аваагүй тохиолдолд мэдэгдэл үлдээсэн өдрөөс 7 хоногийн дотор хаанаас яаж авч болох мэдээллийг шуудангийн хайрцагт, байхгүй бол хаалган дээр хэрэв ажлын газрын хаягаа өгсөн бол тэр газар нь үлдээсэн байна. Дээрхи хугацаанд захидлыг аваагүй байвал олгох хугацааг анхны мэдэгдэл очсоноос **14 хүртэлх хоногоор сунгаж** дахин мэдэгдэл үлдээнэ.

Анхны мэдэгдэл очсоноос 14 хоногийн дараа захидлыг хүлээн авсанд тооцож бичгийг хавтас хэрэгт үлдээнэ.

## 2.7 ГАДААД ЯВСАН ҮЕД ЗАХИДАЛ ХҮЛЭЭН АВАХ

- Гадаад явах үедээ энд захидлыг нь хүлээн авах итгэмжлэгч тогтоож энэ талаар асуудлыг хөтөлж явуулж байгаа байгууллагад мэдэгдэх хэрэгтэй. Хэрэв дээрхи нөхцөлийг биелүүлээгүй бол захидлыг урьд нь заасан хаягаар хүлээн авсан гэж үзнэ.
- Өргөдөл гаргагч хэрэв гадаадад амьдардаг бол Польшид захидал хүлээн авах хүнийг итгэмжлэх үүрэгтэй. Хэрэв Польшид захидал хүлээн авах хүнийг итгэмжлээгүй нөхцөлд тус бичиг олгогдсонд тооцогдон хавтаст хэрэгт үлдэнэ.

## 2.8 ХУГАЦААГ БАРИМТЛАХ ШААРДЛАГА

Польш хэл дээр өргөдөл гаргахдаа тухайн үйлдлийн заасан цаг хугацаанд нь гүйцэтгэх хэрэгтэй. Заасан хугацааг дуусахаас өмнө өргөдлийг дараах байдлаар хүргэсэн бол хүчинтэйд тооцно. Үүнд:

- ▲ 2005 оны 2 сарын 17-ны өдөр батлагдсан нийтийн захиргааны байгууллагыг компьютержуулах хуулийн заалтын дагуу нийтийн захиргааны газарт электрон хэлбэрээр илгээсэн ба түүнийгээ батлах баримттай бол,
- ▲ захиагаа польшийн шуудангийн салбарт өгвөл,
- ▲ өргөдлөө польшийн консулын газарт гаргаж өгвөл,
- ▲ цэрэг хүн байвал өөрийн цэргийн даргадаа өгвөл,
- ▲ усан цэрэг өөрийн усан онгоцны даргадаа өгвөл,
- ▲ хоригдол хүн шоронгийн захиргаандаа өгвөл.

Мөн өргөдлийг асуудлыг хэлэлцэх үндсэн байгууллагад гаргаж өгч болно.

Түүнээс гадна өргөдөл хүлээн авсан хугацааг тооцохдоо:

- ▲ өөр орны шуудангаар явуулсан байвал польшийн шуудангийн салбарт орж ирсэн хугацаа (шуудангийн салбарын тамга дээрхи хугацаа)
- ▲ яаралтай шуудангаар явуулсан бол (Польшидоо явуулсан ч гэсэн, гадаадаас явуулсан ч гэсэн ) тухайн албан байгууллагад ирсэн хугацаагаар тооцно.

Дутагдаж байгаа бичиг баримтыг нэмж авч ирэхэд олгох хугацаа дууссан тохиолдолд гадаадын иргэн тухайн учир шалтгаан дууссан өдрөөс 7 хоногийн дотор хугацааг сэргээх хүсэлт гаргаж болно. Хугацаандаа амжиж авчирч чадаагүй шалтгаан нь тухайн хүнээс хамааралгүй байсан гэдгийг нотолж үзүүлэх нь чухал. Хүсэлт гаргахын хажуугаар дутагдаж буй баримтуудыг авчирч өгөх шаардлагатай.

## 2.9 ХЭРГИЙН ЯВЦТАЙ ТАНИЛЦАХ

- ✦ Асуудлыг ямар ч үе шатанд өргөдөл гаргагч хавтаст хэрэгтэй танилцах, тэмдэглэл хийх, хуулбарлаж авах эрхтэй. Энэхүү эрхийг асуудал шийдвэрлэх хугацаа дууссаны дараа ч эдлэх эрхтэй.
- ✦ Өргөдөл гаргагчид чухал шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хавтаст хэргээс баталгаажуулсан хуулбарыг түүний шаардлагыг харгалзан өгч болно.
- ✦ Хавтаст хэрэгт байгаа материалуудаас баталгаажуулсан хуулбар хийж өгөхөд, хуудас болгоноос 5 золотын тэмдэгтийн хураамж авна.
- ✦ Асуудалд идэвхитэй оролцох. Нийтийн захиргааны байгууллагууд нь асуудлыг хэлэлцэх шат бүр дээр талуудад идэвхитэй оролцох боломж олгох үүрэгтэй. Тиймд шийдвэр гаргахын өмнө цуглуулсан баримт материал дээр үндэслэсэн санал бодол гаргах боломжийг талуудад олгох үүрэгтэй.
- ✦ Өргөдөл гаргагч цугларсан баримт материалтай танилцаж, өргөдөлд нэмэх зүйл байвал нэмэх, тодорхойлолт гаргах боломжтой.

## 2.10 ТЭМДЭГТИЙН ХУРААМЖ

Хууль ёсоор оршин суух ямар ч хэлбэрийн зөвшөөрөл авахад шаардлагатай тэмдэгтийн хураамжийн төлбөрийг төлөх хариуцлага нь өргөдөл гаргаж өгсөн тэр үеэс эхэлнэ. Тэмдэгтийн хураамжийг тухайн мужийн татвар хариуцсан албан байгууллагууд (засаг дарга, хотын дарга)-ын дансанд төлнө. Өргөдөл гаргагч тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг өргөдөлд хавсаргах ёстой.

### Дараахи тэмдэгтийн хураамж төлөгдөх шаардлагатай:

- ✦ түр хугацаанд оршин суух эрх олгох зөвшөөрөл - 340 золот
- ✦ байнга оршин суух эрх олгох зөвшөөрөл - 640 золот
- ✦ Европын Холбооны улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл - 640 золот
- ✦ виза сунгах - 406 золот
- ✦ Шенгений визийг сайн дураар сунгахад - 30 евро
- ✦ дээр дурдсанаас бусад Захиргааны хариуцлагын хуулийг баримталсан шийдвэр - 10 золот
- ✦ тодорхойлолт гаргах -17 золот
- ✦ итгэмжлэгч томилсоныг нотлох баримт эсвэл түүний хуулбарыг өгөхөд - 17 золот

Хэрэв түр хугацаанд оршин суух/байнга оршин суух зөвшөөрөл хүсэгч гадаадын иргэний халамж хамгаалалтанд хүүхдүүд нь болон ямар нэг хүн байдаг бол тэмдэгтийн хураамжийг хүн тус бүрийн өмнөөс төлнө.

Хэрэв өргөдөл гаргах үед тэмдэгтийн хураамжийг төлөөгүй бол тухайн байгууллагаас төлбөрийг хийх хугацааг зааж өгнө. Хугацаа нь 7 хоногоос доошгүй, 14 хоногоос хэтрэхгүй байна. Заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй бол өргөдөл буцаагдана. Тэмдэгтийн хураамж төлөх зүйлсийн нарийвчилсан жагсаалт, төлбөрийн үнэлгээ, түүнээс чөлөөлөгдөх талаар тодорхой мэдээллийг тэмдэгтийн хураамжны талаархи 2006 оны 11-р сарын 16-ны хуулийн хавсралтаас үзэж болно. (хуулийн 225-р дугаар 1635-р заалт, сүүлд өөрчлөгдсөн)

## **ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙГ БУЦАЖ ОЛГОХ**

**Тэмдэгтийн хураамж төлөгдсөн ч гэсэн шийдвэрлэгдэх асуудлууд үр дүнд хүрээгүй ба зөвшөөрөл, тодорхойлолт гараагүй бол өргөдөл гаргагчийн хүсэлтээр хураамжийн төлбөрийг буцааж олгоно. Төлбөрийг төлсөн оноос эхэлж тооцоод 5 жилийн хугацаа өнгөрсөн бол тэмдэгтийн хураамжийг буцаж олгохгүй.**

**Дээр дурдсан тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 1-р заалтын 12-бүлэгт бичсэнээр тэмдэгтийн хураамжийг дүүргийн засаг дарга, хотын засаг дарга хариуцана.**

## БҮЛЭГ III

### ВИЗ СУНГАХ

#### 3.1 ӨРГӨДЛИЙГ АВЧ ХЭЛЭЛЦЭХ БАЙГУУЛЛАГА

Шенгений визийг ба орон нутгийн визийг сунгуулах өргөдлийг гадаадын иргэн амьдарч байгаа газрынхаа харьяа мужийн захиргаанд гаргана.

#### 3.2 ОРОН НУТГИЙН ВИЗИЙГ СУНГАХ

Польш улсын нутаг дэвсгэр дээр байгаа гадаадын иргэн дараах нөхцлийг **хамтад** нь биелүүлж байгаа нөхцөлд орон нутгийн визний хүчинтэй хугацааг эсвэл визэнд хамрагдсан оршин суух хугацааг **сунгаж болно**. Эдгээр нөхцөлд :

- 1) гадаадын иргэний **ажил мэргэжилийн эсвэл хувийн ашиг сонирхолд чухал ач холбогдолтой**, эсвэл **хүмүүнлэгийн шалтгааны** үүднээс орон нутгийн визний хугацаа дуусахаас өмнө эсвэл визэнд хамрах оршин суух хугацааг дуусахаас өмнө энэ улсыг орхиж гарах боломжгүй бол;
- 2) орон нутгийн виз-г сунгуулах шалтгаантай нөхцөл байдал нь **гадаадын иргэний оролцоогүйгээр** бий болсон ба орон нутгийн виз авах үед урьдчилж мэдэх аргагүй байсан;
- 3) гадаадын иргэний Польш улсад оршин суугаа зорилго нь мэдэгдсэнээс нь өөр биш бол;
- 4) орон нутгийн виз олгоход татгалзах өөр ямар нэг нөхцөл илрээгүй зэрэг орно.

#### Эмнэлэгт хэвтэх

Эмнэлэгт хэвтэж байгаа гадаадын иргэн биеийн байдлаасаа болж Польш улсын нутаг дэвсгэрийг орхиж гарах аргагүй бол биеийн байдал нь Польш улсыг орхиж гарах боломжтой болох тэр өдрийг хүртэл визэнд хамарсан оршин суух хугацаа ба орон нутгийн визний хугацааг сунгана.

#### ОРШИН СУУХ ХУГАЦАА

Орон нутгийн визийг **нэг удаа сунгаж болно**. Сунгасан орон нутгийн визний үндэс дээр Польш улсын нутаг дэвсгэр дээр **оршин суух хугацаа 1 жилийг хэтэрч болохгүй**.

**АНХААР:** Визний хүчинтэй хугацаа нь визний үндсэн дээр хүчинтэй оршин суух хугацаатай үргэлж адил байдаггүй.

#### 3.3 ШЕНГЕНИЙ ВИЗИЙГ СУНГАХ

Польш улсын нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа гадаадын иргэний визний хүчинтэй хугацаа буюу визэнд хамрагдсан оршин суух хугацааг дараах тохиолдолд сунгаж **болно**.

- **өөрөөс нь хамаарахгүй эсвэл хүмүүнлэгийн шалтгаанаар** визний хүчинтэй хугацаа дуусахаас өмнө ба визэнд хамрагдсан оршин суух хугацааг дуусахаас өмнө гишүүн орны нутаг дэвсгэрийг орхиж гарах боломжгүй шалтгааныг харуулж чадсан бол.
  - **Дээр дурьдсан шалтгаанаар виз сунгахад төлбөргүй.**
- өөрт нь чухал шалтгааны үүднээс хүчинтэй хугацааг болон оршин суух хугацааг сунгуулах баримт харуулж чадвал.
  - **Дээр дурдсан шалтгаанаар виз сунгахад 30 евроны төлбөртэй.**

## ОРШИН СУУХ ХУГАЦАА

Польш улсын нутаг дэвсгэр дээр сунгасан визний үндсэн дээр **оршин суух хугацаа нь** тухайн визэнд хамааралтай дээд хугацааг **хэтрэх ёсгүй**. Шенгений визний хувьд энэ хугацаа нь тухайн **3 сар** байдаг.

**АНХААР:** Визний хүчинтэй хугацаа нь визний үндсэн дээр хүчинтэй оршин суух хугацаатай үргэлж адил байдаггүй.

## 3.4 ӨРГӨДЛИЙГ ГАРГАХ ХУГАЦАА

Гадаадын иргэн хэрэв:

▲ **Шенгений виз**

▲ **орон нутгийн виз**

зэрэг визний үндсэн дээр оршин суух хугацаагаа сунгуулах зорилготой байгаа бол өөрийн амьдарч байгаа газрын харьяа мужийн захиргаанд виз сунгуулах өргөдлийг одоо хүчинтэй байгаа **визэнд заасан хугацааг дуусахаас дор хаяж 3 хоногийн өмнө гаргана.**

**Өөрөөс нь хамаарахгүй буюу хүмүүнлэгийн шалтгаанаар** визний хүчинтэй хугацаа дуусахаас өмнө ба визэнд хамрагдсан оршин суух хугацааг дуусахаас өмнө гишүүн орны нутаг дэвсгэрийг орхиж гарах боломжгүй, эсвэл гадаадын иргэн **эмнэлэгт хэвтэж байгаа** тохиолдолд өргөдлийг **Шенгений ба орон нутгийн визэнд заасан хүчинтэй хугацааны эцсийн өдөр гаргаж болно.**

Хугацаанаас нь хэтрүүлж гаргасан **өргөдлийг авч үзэхгүй.**

Дээрхи хугацаанд гаргасан өргөдлийг мужийн захиргаа хүлээн авсаныг баталж аялалын бичиг баримт дээр нь **тамга дарж** өгнө.

Гадаадын иргэн өргөдөлийг хугацаанд нь гаргаж, бүх хүснэгтийг нь бөглөж, дутуу баримтыг хугацаанд хавсаргасан бол энэ өдрөөс эхлэн орон нутгийн ба Шенгений визийг сунгах асуудлын хариу албан ёсоор гарах өдөр хүртэл **гадаадын иргэнийг Польш улсын нутагт хууль ёсоор байгаа гэж үзнэ.**

Орон нутгийн ба Шенгений визийг сунгах үйл явц өргөдөл гаргагчийн хүсэлтээр түр хойшлогдсон бол тэр хугацаа нь **хууль ёсоор амьдарч** байгаад **тооцогдохгүй**.

**АНХААР:**

Гадаад паспорт дээр дарсан тамга нь тухайн хүнд Шенгений бусад орноор аялах эрх олгохгүй, харин гадаадын иргэн өөрийн улс руу явахад чөлөөтэй.

### **3.5 АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ**

Шенгений ба орон нутгийн визийг сунгах асуудлын хариу шийдвэрээр гарна. Шенгений ба орон нутгийн визийг сунгасан тохиолдолд түүнийг аялалын бичиг баримт дээр наана.

### **3.6 БИЧИГ БАРИМТУУД**

Шенгений ба орон нутгийн виз сунгуулахаар хөөцөлдөж байгаа гадаадын иргэн хүчинтэй аялалын бичиг баримтыг харуулж, өргөдөлд үндэслэл гаргаж дараах бичиг баримтыг хавсаргах үүрэгтэй. Үүнд:

- 1. сүүлд авахуулсан 4 хувь зураг – урагдаж гэмтээгүй, сүүлийн 6 сарын дотор авахуулсан, 35 х 45 мм хэмжээтэй ар талдаа цайвар дэвсгэртэй, хурц тод өнгийн, нүд болон царайг тод харуулсан, толгойны оройноос мөр хүртэл биеийн хэсэг орсон ба түүндээ нүүрний хэсэг зургийн 70-80% - ийг эзэлсэн, царайны энгийн байдал харуулсан, амаа жимийсэн, алчуур, болон хар нүдний шил зүүгээгүй, нүдээ нээсэн, нүүр лүү үс ороогүй байх.**
- 2. батлах баримтууд:**
  - ⤴ Шенгений ба орон нутгийн визийг сунгуулах шалтгаан ба оршин суух зорилгыг батлах бичиг баримт;
  - ⤴ Орон нутгийн виз сунгахад-эрүүл мэндийн даатгалтай гэсэн бичиг. Улсаас санхүүждэг эмчилгээний даатгал ба жуулчилах үед үзүүлэх эмчилгээний даатгал ба жуулчилах үед үзүүлэх эмчилгээний даатгалын хэмжээ дор хаяж 30.000 евро-ноос доошгүй байхаас гадна Польш улсын нутаг дэвсгэр дээр байхаар төлөвлөсөн хугацааны турш хүчинтэй байх, мөн тухайн орны нутаг дэвсгэр дээр байх үед үзүүлэх эмчилгээний шалтгаанаас болж буцах шаардлага гарсан, яаралтай эмнэлгийн тусламж үзүүлэх хэрэг гарсан, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх ба нас барсан зэрэг тохиолдлуудад эмнэлгийн тусламж үзүүлсэн байгууллагын гаргасан бүхий л зардлыг даатгал хийгч нь бүрэн нөхөн төлнө гэсэн баталгаа,
  - ⤴ **Шенгений виз сунгуулахад 30.000 евро-ноос доошгүй даатгалын сантай эмчилгээний аялалын даатгалтай байх,**
  - ⤴ Өргөдөлд дурдсан бусад нөхцөл байдлыг батлах баримтууд орно.

### **АЯЛАЛЫН БИЧИГ БАРИМТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**



**Шенгений ба орон нутгийн виз сунгуулахаар хөөцөлдөж байгаа гадаадын иргэний аялалын бичиг баримт дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:**

- 1) аялалын бичиг баримтын **хүчинтэй хугацаа** нь дахин сунгагдсан визний хүчинтэй хугацаанаас дор хаяж 3 сараар илүү хүчинтэй байх.
- 2) **дор хаяж 2 ширхэг** цэвэр хуудастай байх
- 3) сүүлийн **10 жилд олгогдсон** байх зэрэг болно.

## **БҮЛЭГ IV**

### **ТҮР ХУГАЦААНД ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ**

Польш улсын нутаг дэвсгэр дээр **3-с дээш хугацаанд** амьдрах шалтгаантай нөхцөлд түр хугацаанд оршин суух зөвшөөрлийг хөөцөлдөж болно.

#### **4.1 ТҮР ХУГАЦААНД ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮНДЭСЛЭЛҮҮД**

##### **1. АЖИЛ ЭРХЛЭХ**

гадаадын иргэн **ажлын зөвшөөрөлтэй** буюу ажлын зөвшөөрөл шаардлагагүй ажил эрхэлж байгаа бол **ажил олгогчийн гаргасан тодорхойлолттой** үед,

##### **2. ХУВИАРАА АЖИЛ ЭРХЛЭХ**

Польш улсад мөрдөгдөж байгаа хуулийн дагуу явуулж байгаа бөгөөд үйл ажиллагаа нь үндэстний ашиг сонирхолд нийцэж байгаа, ялангуяа хөрөнгө оруулалтын хэмжээг өсгөж байгаа, технологийн орчин үеийн шийдлийг оруулж ирсэн ба хэрэгжүүлж байгаа болон ажлын байр шинээр үүсгэж байгаа тохиолдолд,

##### **3. УРЛАГИЙН ЗҮТГЭЛТЭН**

Хэрэв урлагийн зүтгэлтэн Польш улсад өөрийн урлагийн ажилыг үргэлжлүүлэх хүсэлттэй бол,

##### **4. СУРГАЛТ БА АЖЛЫН ДАДЛАГА ХИЙХ**

Хэрэв тэдгээр нь Европын Нэгдсэн Холбооны хүрээнд явагдаж байгаа,

##### **5. ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНЭЭР АМЬДРАХ**

1961 оны 10-р сарын 18-нд Туринд хийгдсэн Европын бүх нийтийн картад дурдсан шилжин явж байгаа ажилтантай хамтран амьдрах зорилготой тохиолдолд, (1999 оны хуулийн 67-р зүйл, дугаар 8)

##### **6. ПОЛЬШИЙН ИРГЭНТЭЙ ГЭР БҮЛ БОЛОХ**

##### **7. ГЭР БҮЛТЭЙГЭЭ НЭГДЭХ**

Хэрэв гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр гэр бүлтэйгээ нэгдэх зорилгоор орж ирсэн буюу амьдарч байгаа нөхцөлд,

##### **8. ГАДААДЫН ИРГЭН ПОЛЬШ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭР ДЭЭР ТӨРСӨН БАГА НАСНЫ ХҮҮХЭДТЭЙГЭЭ ҮЛДЭХ**

Бага насны гадаадын иргэн тухайн улсын нутаг дэвсгэр дээр харж хандах хүнгүй байгаа үед,

**9. ГАДААДЫН ИРГЭН ГЭР БҮЛИЙН ХҮНТЭЙГЭЭ ЭСВЭЛ НАСАНД ХҮРСЭН ХҮҮХЭДТЭЙГЭЭ ҮЛДЭХ**

Хэрэв гадаадын иргэн 7-р (гэр бүлтэйгээ нэгдэх) хэсэгт дурьдсан нөхцөлийн үндэслэлээр Польш улсын нутаг дэвсгэр дээр түр хугацаагаар амьдрах зөвшөөрөлийн үндсэн дээр 5-с доошгүй жил амьдарч байгаа бол,

**10. БЭЛЭВСРЭЛТ, САЛАЛТ, ТУСДАА АМЬДРАХ, НАС БАРАХ**

Гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр 7-р хэсэгт заасан (гэр бүлтэйгээ нэгдэх) үндэслэлээр түр хугацаанд амьдрах зөвшөөрөлтөйгөөр оршин сууж байгаа, хэрэв гадаадын иргэнд харгалзаж үзэх онц чухал ашиг сонирхол байвал,

**11. БЭЛЭВСЭРЧ ҮЛДЭХ БА САЛАХ**

Гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр 6-р хэсэгт заасан (польшийн иргэнтэй гэр бүл болох) үндэслэлээр түр хугацаанд амьдрах зөвшөөрөлтөйгөөр оршин сууж байгаа, хэрэв гадаадын иргэнд харгалзаж үзэх онц чухал ашиг сонирхол байвал,

**12. ГАДААДЫН ИРГЭН ПОЛЬШ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭР ДЭЭР ТӨРСӨН БАГА НАСНЫ ХҮҮХЭД ТЭЙГЭЭ ҮЛДЭХ**

Хэрэв Польш улсын нутаг дэвсгэр дээр амьдрах зөвшөөрөлтэй гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр төрсөн бага насны хүүхэдтэй бол,

**13.ЕВРОПЫН НЭГДСЭН ХОЛБООНЫ ӨӨР НЭГ ОРОНД УДААН ХУГАЦААГААР АМЬДРАХ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БОЛ**

Хэрэв гадаадын иргэн Польш улсад хүчин төгөлдөр хуулийн дагуу ажил эрхлэх ба хувийн компани эрхлэх, сургуульд орох ба үргэлжлүүлж сурах эсвэл мэргэжилийн сургалт хийх болон Польш улсын нутаг дэвсгэр дээр амьдрах өөр учир шалтгаан байгааг харуулж чадвал,

**14. 13-Р ЗҮЙЛД ЗААСАН ГАДААД ИРГЭНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮН БАЙХ**

Хэрэв гадаадын иргэн 13-р зүйлд заасан гадаадын иргэний гэр бүлийн гишүүн бөгөөд Европын нэгдсэн холбооны өөр нэг оронд хамт амьдарч байсан, хамт явж байгаа буюу хамтран амьдрах хүсэлтэй бол,

**15. ХҮНИЙ НАЙМААНЫ ЗОЛИОС БОЛОХ**

Хэрэв гадаадын иргэн 2002 оны 7-р сарын 19-нд батлагдсан хүний наймаатай тэмцэх Удирдлагын зааварчилгааны шийдвэрт тусгагдсаны дагуу хүний наймааны золиос болсон бөгөөд дараах нөхцөлийг биелүүлж байгаа бол,

1.Польш улсын нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа,

2. хүний наймааны эсрэг тэмцэх чигэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллаж эхэлсэн бол,
3. хүний наймаатай холбоотой хориотой үйл ажиллагаа явуулагч хүмүүстэй харилцаа холбоогоо тасалсан бол,

**16. ДЭЭД МЭРГЭЖИЛ ЭЗЭМШИХ БА ДОКТОРАНТУРЫН ЧИГЭЛЭЭР СУУРИН ХЭЛБЭРЭЭР ИХ СУРГУУЛЬД ЭЛСЭН СУРГУУЛЬД ОРОХ БА ҮРГЭЛЖЛҮҮЛЖ СУРАЛЦАХ**

Гадаадын иргэн дээд мэргэжил эзэмших болон докторантурын чиглэлээр их сургуульд элсэж орохоор болон үргэлжлүүлж сурах, цаашид “ сургалт” гэж нэрлэгдсэн зорилгоор, Польш улсын нутаг дэвсгэр дээр орж ирэх ба амьдрах тохиолдолд болон өөр Европын Нэгдсэн Холбооны гишүүн оронд их сургуульд элсэн орсон бөгөөд цаашид түүнийгээ Польш улсад үргэлжлүүлж суралцах хүсэлтэй бол,

**17. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СУДАЛГАА ЯВУУЛАХ**

Хэрэв гадаадын иргэн эрдэмтэн бөгөөд тухайн боловсролын асуудал хариуцсан яамны баталсан хэрэгжүүлэгч газар хэрэгжих эрдэм шинжилгээний төсөлд хамрагдсан гэрээний үндэс дээр Польш улсын нутаг дэвсгэр дээр эрдэм шинжилгээний судалгаа явуулах зорилгоор орж ирсэн ба амьдарч байгаа тохиолдолд,

**18. „ЭРДЭМТЭН” ГЭСЭН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ОРШИН СУУХ БИЧИГ БАРИМТТАЙ БАЙХ**

Европын Нэгдэлийн Удирдлагын баталсан 2002 оны 6-р сарын 13-ны өдрийн 1030/2002 дугаарын (2002 оны 6 сарын 15-ны Европын Холбооны хуулийн L 157, 1-7 хуудас) Европын Холбооны гишүүн бусад орны гаргасан „эрдэмтэн” гэсэн тэмдэглэлтэй гуравдагч орнуудын иргэдэд олгох оршин суух бичиг баримтын нэгдсэн загварыг тогтоох хуулийн 2-р заалтын 1-р бүлгийн а дугаарт бичсэний дагуу судалгааны төслийг хэрэгжүүлэх зорилгоор тухайн орны эрдэм шинжилгээний газартай гэрээ хийсэн бөгөөд тэр эрдэм шинжилгээний судалгаагаа мөн Польш улсын нутаг дэвсгэр үргэлжлүүлж хийхээр төлөвлөж байгаа тохиолдолд,

**19. ТУРК УЛСЫН ИРГЭД**

**Хэрэв Турк улсын иргэн 1963 оны 9 сарын 12-нд Анкарт Турк улс Европын Эдийн засгийн Холбоотой хуулийн үндэслэлээр зааварчилгаагаар байгуулагдсан хамтарсан холбооны гэрээний дагуу Польш улсын нутаг дэвсгэр дээр ажиллах эрхтэй бол,**  
(1964 оны 12 сарын 29-ны Европын Холбооны хуулийн L 217, 3687-р хуудас)

Түүнээс гадна **гадаадын иргэнд** дараах нөхцөлөөр түр амьдрах эрх **олгож болно:**

**20. СУРЧ БОЛОВСРОХ**

**21. МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ**

**22. ГЭР БҮЛИЙН ХОЛБОО**

Хэрэв гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа болон амьдрахаар төлөвлөж байгаа Польшийн иргэн эсвэл Европын Чөлөөт Худалдааны Зөвшилцөл (ЕФТА)-ийн ба Европын Эдийн Засгийн Бүсийн буюу Швейцарийн Конфедерацийн гишүүн орнуудын иргэн эсвэл Европын Холбооны гишүүн улсын иргэнтэй нэгдэх зорилготой байгаа бол;

**23. СҮМ ХИЙДЭД ҮЙЛЧЛЭГЧ ЛАМ, ХУВАРГА, ШАШНЫ БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮН БАЙХ**

Хэрэв гадаадын иргэн болон олон улсын гэрээний үндсэн дээр статус нь бүрдсэн, улсаас сүм хийд эсвэл бусад шашны байгууллагын талаар гаргасан хуулиар бүртгэгдсэн шашны байгууллагын гишүүн ба сүм хийдийн лам хуварга бөгөөд энэ үүргээ биелүүлэхээр Польш улсын нутаг дэвсгэр дээр байгаа бол;

**24. БУСАД НӨХЦӨЛ ШАЛТГААНУУД**

Гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр амьдрах шаардлагатай гэсэн өөр нөхцөл шалтгааныг нотолж чадах бол.

**4.2 ПОЛЬШ УЛСАД ХУУЛЬ БУСААР АМЬДРЧ БАЙГАА ТОХИОЛДОЛД ТҮР ХУГАЦААГААР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ**

**Польш улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар амьдарч байгаа гадаадын иргэнд дараах тохиолдолд түр хугацаагаар амьдрах зөвшөөрөл олгож болно:**

1. Польш улсын хуульд заасны дагуу гадаадын иргэн заавал өөрийн биеэр олон нийтийн хариуцагч байгууллагад хүрч ирэх шаардлагатай байгаа бол,
2. хувийн онцгой шалтгаантай үүднээс Польшийн газар нутаг дээр байх шаардлагатай байгаа бол,
3. Польш улсын ашиг сонирхолд нийцэж байгаа бол,
4. хүний наймаатай тэмцэх байгууллагын үзэж байгаагаар гадаадын иргэн 2002 оны 7 сарын 19-ны Удирдлагын үндсэн шийдвэрийн дагуу хүний наймааны золиос болсон байх магадлалтай бол. (2002 оны 8 сарын 1-ны Европын Нэгдсэн Холбооны Хуулийн L203, Европын Нэгдсэн Холбооны Польш хэл дээрхи тусгай эмхэтгэлийн 19-р бүлгийн 6-р заалт, 52-р хуудас )

**4.3 ӨРГӨДӨЛД ХАМААТАЙ НЭМЭЛТ ШААРДЛАГУУД**

Гадаадын иргэн одоо хүчинтэй байгаа виз болон түр хугацаанд оршин суух зөвшөөрлийнхөө хугацааг дуусахаас дор хаяж **45 хоногийн өмнө** түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл авахаар өөрийн харьяалагдах мужид өргөдөл гаргах ёстой.

**Энэхүү 45 хоногийн хугацаа нь сунгагдах боломжгүй.**

Хугацаанд нь гаргасан, бүх хүснэгт нь бөглөгдсөн, дутуу баримтыг хугацаанд хавсаргасан өргөдлийг мужийн ажилтан хүлээн авахдаа баталгаажуулж **тамга дарна.**

**Энэ өдрөөс эхлэн зөвшөөрөл албан ёсоор гарах өдөр хүртэл гадаадын иргэнийг Польш улсын нутагт хууль ёсоор байгаа гэж үзнэ.**

Түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгох үйл явц өргөдөл гаргагчийн хүсэлтээр түр хойшлогдсон бол **тэр хугацаа нь хууль ёсоор амьдарч байгаад тооцогдохгүй.**

#### **АНХААР:**

**Гадаад паспорт дээр дарсан тамга нь тухайн хүнд Шенгений орноор аялах эрх олгохгүй, харин гадаадын иргэн өөрийн улсууд явахад чөлөөтэй.**

Гадаадын иргэн өргөдөлөө одоо хүчинтэй байгаа виз болон түр хугацаанд оршин суух зөвшөөрлийнхөө хугацааг дуусахаас **45 хоногийн өмнө амжиж гаргаж чадаагүй** ба эдгээр бичиг баримтын хүчинтэй хугацааг дуусахаас өмнө шинээр бичиг баримт олгох асуудал шийдэгдэж амжаагүй нөхцөлд гадаадын иргэн виз болон түр хугацаанд оршин суух зөвшөөрлийнхөө хугацааг дуусахаас өмнө **Польшийн нутаг дэвсгэрийг орхиж гарах** үүрэгтэй.

Хэрэв Польшийн нутаг дэвсгэрийг орхиж гараагүй бөгөөд Польш улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар үлдсэн бол Мужийн захиргаа тухайн хүнд түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийг олгохоос татгалзах үүрэгтэй.

Гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр түр хугацаанд болон байнга оршин суух, Европын Холбооны улсад удаан хугацаагаар оршин суух дараагийн зөвшөөрлийг олж аваагүй нөхцөлд Польш улсын нутаг дэвсгэрийг орхин гарах үүрэгтэй. Гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр шаардлагатай визгүйгээр, түр хугацаанд болон байнга оршин суух эсвэл Европын Холбооны улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлгүйгээр амьдарч байсан ба хууль зөрчиж ажил хийх ба хувиараа ажил эрхлэхийг завдсан бол эдгээр үйлдэл нь тухайн гадаадын иргэнийг Польш улсын нутаг дэвсгэрээс албадан гаргах мөн 5 хүртэлх жилийн хугацаанд дахин орж ирэх эрхгүй болгох зэрэг шийдвэрийг гаргахад хүргэнэ. Түүнээс гадна Польш улсаас гаргах шийдвэр гарсан тухайн гадаадын иргэний нэр ус нь Шенгений Мэдээллийн Системд (SIS)-д оруулагдаж бусад **Шенгений** орнууд руу дээрхи хугацаанд нэвтрэхэд татгалзах үндэс болно.

#### **4.4 ӨРГӨДЛИЙГ АВЧ ХЭЛЭЛЦЭГЧ БАЙГУУЛЛАГА**

Түр хугацаанд амьдрах зөвшөөрөл авах өргөдлийг **гадаадын иргэний харьяа мужийн захиргаанд** гаргах ба хэрэв гадаадын иргэн хилийн цаана байгаа бол **гадаад иргэний амьдрахаар төлөвлөж байгаа мужийн захиргаанд консулаар дамжуулан гаргаж болно.**

#### **4.5 БИЧИГ БАРИМТУУД**

Гадаадын иргэн:

- ✦ хүчинтэй аялалын бичиг баримтаа танилцуулах:

Онцгой шалтгаанаар хэрэв гадаадын иргэн аялалын бичиг баримт байхгүй бөгөөд олж авах боломжгүй нөхцөлд биеийн байцаалтыг нь нотлох өөр бичиг баримт үзүүлж болно;

▲ өргөдөлийн маягтыг бөглөж, дараах зүйлсийг хавсаргах:

- **сүүлд авуулсан 4 хувь зураг** – урагдаж гэмтээгүй, сүүлийн 6 сарын дотор авуулсан, 35 x 45 мм хэмжээтэй ар талдаа цайвар дэвсгэртэй, хурц тод өнгийн зураг, нүд болон царайг тод харуулсан, толгойны оройноос мөр хүртэл биеийн хэсэг орсон ба түүндээ нүүрний хэсэг зургийн 70-80% - ийг эзэлсэн, царайны энгийн байдал харуулсан, амаа жимийсэн, алчуур, болон хар нүдний шил зүүгээгүй.
- өргөдөл гаргах болсон шалтгаан болон **түүнд бичигдсэн мэдээллүүдийг батлах бичиг баримтууд**
- **гэмдэгтийн хураамж төлсөн баримт**
- **эрүүл мэндийн даатгалд хамрагдсан гэсэн бичиг баримт үүнийг ойлгохдоо нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсвэл Польш улсын нутаг дэвсгэр дээр эмчилгээ хийх зардлыг хариуцана гэсэн даатгагчийн баталгаа зэрэг орно.** Дээр дурьдсан бичиг баримтыг дараах нөхцөлөөр түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл хүсч байгаа үед хавсаргах ёстой. Үүнд:
  - ажил эрхлэх (1-р зүйл); хувиараа ажил эрхлэх (2-р зүйл); гэр бүлтэйгээ нэгдэх (7-р зүйл); Европын Нэгдсэн Холбооны өөр нэг оронд удаан хугацаагаар амьдрах зөвшөөрөлтэй бол (13-р зүйл); дээд сургуульд суурин хэлбэрээр суралцахаар элсэж орох ба үргэлжлүүлж суралцах (16-р зүйл); сурч боловсрох (20-р зүйл); мэргэжил дээшлүүлэх сургалт (21-р зүйл); гэр бүлийн холбоо (22-р зүйл); бусад шалтгаанаар (24-р зүйл) **болон**
  - 54-р бүлэгт дурьдсан гадаадын иргэний гэр бүлийн хүн эсвэл хүүхэд (9-р зүйл); 13-р зүйлд дурдсан гадаадын иргэний гэр бүлийн гишүүн (14-р зүйл);
- **өөрийн болон гэр бүлийн гишүүдийн амьдрах зардлыг нөхөж чадахуйц байнгын тогтмол орлогын эх үүсвэртэй гэдэгийг батлах баримтууд.** Энэ бичиг баримтыг дараахи нөхцөлөөр түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл хөөцөлдөж байгаа үед хавсаргах хэрэгтэй. Үүнд:
  - ажил эрхлэх (1-р зүйл); хувиараа ажил эрхлэх (2-р зүйл); гэр бүлтэйгээ нэгдэх (7-р зүйл); Европын Нэгдсэн Холбооны өөр нэг оронд удаан хугацаагаар амьдрах зөвшөөрөлтэй бол (13-р зүйл); сурч боловсрох (20-р зүйл); мэргэжлэх дээшлүүлэх сургалт (21-р зүйл); гэр бүлийн холбоо (22-р зүйл); бусад шалтгаанаар (24-р зүйл); болон
  - 54-р заалтад дурдсан гадаадын иргэний гэр бүлийн хүн эсвэл хүүхэд (9-р зүйл); 13-р зүйлд дурдсан гадаадын иргэний гэр бүлийн гишүүн (14-р зүйл).
- **амьдрах хугацаандаа хэрэглэх болон эх орондоо буцаж очих зардалаа нөхөж чадахуйц санхүүгийн хөрөнгөтэй гэсэн баримт бичгийг батлан харуулах.** Эдгээр баримтуудыг дараах нөхцөлөөр түр оршин суух зөвшөөрөл хөөцөлдөж байгаа үед хавсаргах хэрэгтэй. Үүнд:
  - дээд сургуульд суурин хэлбэрээр суралцахаар элсэж орох ба үргэлжлүүлж суралцах (16-р зүйл);

- сурч боловсрох (20-р зүйл) **болон**
- эрдэмтэд (17-р зүйл); „эрдэмтэн” гэсэн тэмдэглэгээтэйгээр оршин суух бичиг баримттай гадаадын иргэд (18-р зүйл);
- гадаад иргэний амьдарч байгаа ба амьдрахаар зэхэж байгаа байранд **албан ёсоор**

**бүртгэгдсэн гэсэн бичиг баримт.** Гадаад иргэний амьдарч байгаа ба амьдрахаар зэхэж байгаа байранд **албан ёсоор бүртгэгдсэн бичиг баримтад байрандаа үнэгүйгээр суулгах гэрээ ордоггүй ч хэрэв суулгаж байгаа хүн гэр бүлийн хүн, хүүхэд ба ойрын хамаатан, хадам аав ээж бол хүчинтэйд тооцогдож болно.**

Байранд бүртгэгдсэн бичгийг дараах нөхцөлөөр түр оршин суух зөвшөөрөл хөөцөлдөж байгаа үед хавсаргах хэрэгтэй. Үүнд:

- ажил эрхлэх (1-р зүйл); хувиараа ажил эрхлэх( 2-р зүйл); гэр бүлтэйгээ нэгдэх (7-р зүйл); Европын Нэгдсэн Холбооны өөр нэг оронд удаан хугацаагаар амьдрах зөвшөөрөлтэй бол (13-р зүйл); сурч боловсрох (20-р зүйл); мэргэжлэх дээшлүүлэх сургалт (21-р зүйл); гэр бүлийн холбоо (22-р зүйл); бусад шалтгаанаар (24-р зүйл); болон
- 54-р заалтад дурдсан гадаадын иргэний гэр бүлийн хүн эсвэл хүүхэд (9-р зүйл); 13-р зүйлд дурдсан гадаадын иргэний гэр бүлийн гишүүн (14-р зүйл).

## ОНЦГОЙ БАЙДАЛ

Польшийн иргэний гэр бүлийн хүн, түр хугацаанд оршин суух эрх авсан гадаад иргэний Польшийн нутаг дэвсгэр дээр төрсөн бага насны хүүхэд, Европын Нэгдсэн Холбооны төслийн шугамаар хэрэгжиж байгаа мэргэжил дээшлүүлэх сургалт ба дадлагат оролцож байгаа гадаадын иргэн болон хүний наймааны золиос болсон зэрэг хүмүүс **байранд албан ёсоор бүртгэгдсэн, тогтмол санхүүгийн орлоготой гэсэн болон эрүүл мэндийн даатгалтай гэсэн баримтуудыг харуулах үүргээс чөлөөлөгдөнө.**

## 4.6 ГЭР БҮЛИЙН ГИШҮҮН

Гадаадын иргэний гэр бүлийн гишүүнд:

- 1) Польш улсын хуулиар **гэр бүл болсон** гэр бүлийн хүн
- 2) Гадаадын иргэн ба Польш улсын хуулиар гэр бүл болсон хүнийх нь **бага насны хүүхэд**, дагавар хүүхэд байж ч бас болно.
- 3) Гадаадын иргэний **бага насны хүүхэд**, үүнд мөн гадаадын иргэн эцэг эхийнх нь үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд асран хамгаалж байгаа дагавар хүүхэд
- 4) 1-р зүйл дээр дурдсан хүний **бага насны хүүхэд**, үүнд мөн эцэг эхийнх нь үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд асран хамгаалж байгаа дагавар хүүхэд
- 5) Польш улсын нутаг дэвсгэр дээр халамжлах хүнгүй амьдарч байгаа **цагаачийн статустай бага насны** гадаад хүүхэдийн гэр бүлээр түүний эцэг эх, өвөг эцэг эхийг тооцоно.

Гадаад иргэдийн тухай хуулийн 54-р заалтын дагуу **гэр бүлтэйгээ нэгдэх зорилгоор түр хугацаанд амьдрах зөвшөөрлийг** Польш улсын нутаг дэвсгэр дээр дараах нөхцөлөөр амьдарч байгаа гадаад иргэний гэр бүлийн гишүүнд олгоно. Үүнд:

- 1.байнга оршин суух зөвшөөрөлтэй



- 2.Европын Нэгдсэн Холбооны улсад удаан хугацаагаар амьдрах зөвшөөрөлтэй
- 3.албан ёсоор цагаачлах эрх авсан
- 4.нэмэлт хамгаалалт олгосон
5. түр оршин суух зөвшөөрлийн үндэслэлээр дор хаяж 2 жилийн хугацаагаар амьдарсан, түүндээ гэр бүлийн гишүүнээр түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдөл гаргахаас яг өмнө 1 жилээс доошгүй хугацаанд оршин суух зөвшөөрөлтэй
- 6.53-р заалтын 1-р зүйлийн 17, 18-д дурдсанаар түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийн үндсэн дээр амьдарч байгаа зэрэг болно.

#### **4.7 ТҮР ХУГАЦААГААР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ ХУГАЦАА**

Түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийг гадаадын иргэний Польш улсын нутаг дэвсгэр дээр амьдрах зорилго тус бүрд тохируулж 2 жилээс дээшгүйгээр олгоно. Түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийг ямар шалтгаанаар хөөцөлдөж байгаагаас шалтгаалж

- **гэр бүлтэйгээ нэгдэх** бол – нэгдэх зорилгоор очиж байгаа оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэний зөвшөөрөлийн хугацаа дуусах хүртэлхи хугацаагаар, хэрэв тухайн гадаадын иргэн байнга оршин суух, Европын Нэгдсэн Холбооны улсад удаан хугацаагаар амьдрах эсвэл Польш улсад цагаачлах эрх авсан бол – 2 жилийн хугацаатайгаар
- **хүний наймааны золиос** болсон гадаадын иргэн – 6 сараар
- **53-р заалтын 2-р зүйлд** заасан гадаадын иргэний зорилгоо биелүүлэхэд шаардлагатай гэж үзсэн хугацаагаар эсвэл хүний наймааны эсрэг тэмцэгч байгууллагатай хамтран ажиллах шийдвэр гаргатал нь – **3 сараас дээшгүйгээр**
- хэрэв **бага насны хүүхэд** бол хуулиар асран хамгаалагч хүнд нь олгосон түр хугацаанд оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусах хүртэл.
- **их сургуульд** элсэж орох ба үргэлжлүүлж сурах – 1 жил
- **мэргэжилийн сургалт эсвэл сургуульд** орох – сургууль эсвэл мэргэжилийн сургалт явагдах хугацааг хамрах боловч 1 жилээс илүүгүйгээр
- **эрдэм шинжилгээний судалгаа** хийх – 1 жил

#### **АНХААР:**

Хэрэв түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл хөөцөлдөж байгаа нөхцөл нь 53-р бүлгийн 1-р заалтын **16-18 зүйл** (16-р зүйл – дээд сургуульд суурин хэлбэрээр суралцахаар элсэж орох ба үргэлжлүүлж суралцах; 17-р зүйл – судалгааны ажил хийх; 18-р зүйл – “эрдэмтэн” гэсэн тэмдэглэлтэйгээр оршин суух бичиг баримттай) бол гадаадын иргэний 1 жилээс богино хугацаагаар Польш улсын нутаг дэвсгэр дээр амьдрах үндэслэл болно.

1-р заалтын 54-р бүлэгт дурдсан дараах тохиолдолд түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийг:

- 1) 16-р зүйл – **суралцах хугацаа нь дуусах хүртэл;**
- 2) 17-р зүйл – **судалгааны ажил дуусах хүртэл;**
- 3) 18-р зүйл - **Польш улсын нутаг дэвсгэр дээр явуулж байгаа эрдэм шинжилгээний ажил дуусах хүртэл хугацаагаар олгоно.**

#### **4.8 ӨРГӨДЛИЙГ ХАРГАЛЗАЖ ҮЗЭХГҮЙ ШАЛТГААН**

Гадаадын иргэнд түр хугацаанд оршин суух зөвшөөрөл өгөх өргөдлийг дараах шалтгаанаар харгалзаж үзэхгүй:

1. **1-р заалтын 26-р бүлэгийн 26-р зүйлд** дурдсаны дагуу зорилгоор зөвхөн Польш улсын нутаг дэвсгэр дээр орж ирэх ба амьдрахад хүчинтэй Шенген-ий визийн үндэс дээр Польш улсын нутаг дэвсгэр дээр байгаа, эсвэл 2 – заалтын 53а бүлгийн (4.2 бүлгийг үз) түр хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй гэхдээ 1-р заалтын 53-р бүлгийн 15-р зүйл (4.2 бүлгийг үз) түр хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй гэхдээ 1-р заалтын 53-р бүлгийн 15-р зүйл (4.1 бүлгийн 15-р зүйл)-ийн нөхцөлөөр түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл хөөцөлдөхөөс бусад нөхцөлд;
2. 110-р бүлэгт дурдсан харуул хамгаалалтын газар албадан гаргах зорилгоор хоригдсон байгаа ба тухайн гадаадын иргэний эсрэг нутаг дэвсгэрээсээ гарах шийд гарсан эсвэл хуулийн үндэсээр гаргасан шийдвэрийн дагуу хоригдсон;
3. оршин суухыг нь хүлээн зөвшөөрсөн

**болон**

4. **өргөдөл бичих зааварчилгааг сахиагүй бол.** Үүнд:

өргөдлийн хүснэгт болгоныг бөглөөгүй бол,  
аялалын бичиг баримт байхгүй бол, онцгой шалтгаантай үед – биеийн байцаалтыг батлах өөр бичиг баримтыг харуулаагүй бол,  
өргөдөлд:

сүүлийн үед авуулсан 4 хувь зураг шаардлагатай нөхцөлд амьдрах байрандаа албан ёсоор бүртгэгдсэн бичиг зэргийг хавсаргаагүй бол:

Польш улсын дэвсгэр дээр байгаа эрдэм шинжилгээний газар гадаадын иргэнийг судалгааны ажил хийлгэх зорилгоор хүлээн авсан гэрээ болон дээр дурдсан газар нь гадаадын иргэний амьдрах ба буцааж явуулах өртөгийг дааж гэрээт хугацаа дууссанаас 6 сарын дотор улсын төсвөөс гаргана гэсэн бичигээр гаргасан тодорхойлолт, хэрэв 1-р заалтын 53-р бүлгийн 17-р зүйлд дурдсан гадаад иргэнийг 1-р заалтын 88-р бүлгийн 1-р зүйлд дурдсан үндэслэлээр гаргах нөхцөл;

Польш улсаас өөр Европын Холбооны улсын нутаг дэвсгэр дээр байгаа эрдэм шинжилгээний газар гадаадын иргэнийг судалгааны ажил хийлгэх зорилгоор хүлээн авсан гэрээ болон дээр дурдсан газар нь гадаадын иргэний амьдрах ба буцааж явуулах өртөгийг дааж гэрээт хугацаа дууссанаас 6 сарын дотор улсын төсвөөс гаргана гэсэн бичигээр гаргасан тодорхойлолт, хэрэв 1-р заалтын 53-р бүлгийн 18-р зүйлд дурдсан гадаад иргэнийг 1-р заалтын 88-р бүлгийн 1-р зүйлд дурдсан үндэслэлээр гаргах нөхцөл;

түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл хөөцөлдөж буй бага насны гадаадын иргэний хуулиар асран хамгаалагчийн зөвшөөрлийг хавсаргаагүй зэрэг шалтгаан орно.

#### **4.9 ТҮР ХУГАЦААГААР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ**

**Дараах шалтгаанаар гадаадын иргэнд түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийг өгөхөөс татгалзаж болно. Үүнд:**

1. 53-536 бүлэгт дурьдсан шаардлагыг биелүүлэхгүй бол;
2. Польш улс өөрийн нутагтаа амьдруулах хүсэлгүй байгаа гадаадын иргэдийн жагсаалтанд гадаадын иргэн бичигдсэн бол;
3. **Шенген-ий Мэдээллийн Системд тухайн орнуудад орох хориотойгоор нэр овог нь бичигдсэн бол;**
4. Гадаадын иргэний Польш улсын нутагт **орж ирэх ба амьдрах зорилго** нь үнэн хэрэгтээ урьд мэдэгдсэнээс **өөр байгааг** хэргийн байдал харуулж байвал;
5. **Түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл авах хууль дүрмийг тойрч гарах үүднээс** Польшийн иргэнтэй ба 54-р бүлэгт дурдсан Польш улсын нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа гадаадын иргэнтэй **гэр бүл болж** түүний үндсэн дээр зөвшөөрөл хөөцөлдөж байгаа бол;
6. Зөвшөөрөл олгох нь Польш улсын ашиг сонирхол, **аюулгүй байдал**, нийтийн ашиг сонирхолд нийцэхгүй тохиолдолд;
7. Түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл өгөх үйл явцын дунд:
  - а) **өргөдөлд ташаа мэдээлэл өгсөн** эсвэл **хуурамч нэр овог мэдээлэл** агуулсан бичиг баримт хавсаргасан;
  - б) **худал мэдүүлэг өгсөн ба үнэнийг нуусан** эсвэл бичиг баримтыг хуурамчаар үйлдэж түүнийгээ жинхэнэ баримт бичиг шиг ашигласан;
8. 2008 оны 12 сарын 5-нд батлагдсан халдварт өвчинтэй тэмцэх ба урьдчилан сэргийлэх хуулийн заалтын үндэслэлээр(234-р хуулийн 1570-р зүйл) эмчлэгдэх үүрэгтэй **халдварт өвчин илэрсэн** ба тэдгээр өвчнөөр өвчилсөн байж болох шинж тэмдэг илэрсэн боловч гадаадын иргэн эмчлүүлэхээс татгалзаж байгаа бол;
9. **улсын санд татвар төлөх үүргээс** зайлсхийж байгаа бол;
10. улсын сангаас газар нутгаасаа явуулах зорилгоор гаргасан **зардлыг нөхөж төлөөгүй бол;**
11. Польш улсын нутаг дэвсгэр дээр **хууль бусаар** байгаа бол;
12. 1-р заалтын 53-р бүлгийн 16-р зүйлд дурдсан үндэслэлээр түр хугацаагаар амьдрах зөвшөөрлийг дахин гаргуулхаар хөөцөлдөж байгаа ч **сурч байгаа жилээ төгсөөгүй ба шалгалтын хугацаагаа дараагийн жил эсвэл дараагийн семестер хүртэл сунгуулаагүй зэрэг орно.**

#### **4.10 ТҮР ХУГАЦААГААР АМЬДРАХ ЗӨВШӨӨРЛИЙГ БУЦААН ТАТАЖ АВАХ**

Гадаадын иргэний түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийг дараах шалтгаанаар татан авч болно. Үүнд:

1. олгосон шалтгаан нь дуусгавар болсон бол;
2. дараах дурдсан нөхцөлүүдийн аль нэг нь бий болсон бол:
  - Польш улс өөрийн нутагтаа амьдруулах хүсэлгүй байгаа гадаадын иргэдийн жагсаалтанд гадаадын иргэн бичигдсэн бол;
  - гадаадын иргэний Польш улсын нутагт орж ирэх ба амьдрах зорилго нь үнэн хэрэгтээ урьд мэдэгдсэнээсээ **өөр байгааг** хэргийн байдал харуулж байвал;
  - түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл авах хууль дүрмийг тойрч гарах үүднээс Польшийн иргэнтэй эсвэл 54-р бүлэгт дурдсан Польш улсын нутаг

дэвсгэр дээр амьдарч байгаа гадаадын иргэнтэй гэр бүл болсоны үндсэн дээр зөвшөөрөл хөөцөлдөж байгаа бол;

- зөвшөөрөл олгох нь Польш улсын ашиг сонирхол, аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд нийцэхгүй тохиолдолд;

- түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл өгөх нь үйл явцын дунд:

- өргөдөлд ташаа мэдээлэл өгсөн эсвэл хуурамч нэр овог мэдээлэл агуулсан бичиг баримт хавсаргасан;

- худал мэдүүлэг өгсөн ба үнэнийг нуусан эсвэл бичиг баримтыг хуурамчаар үйлдэж түүнийгээ жинхэнэ баримт бичиг шиг ашигласан;

- 2008 оны 12 сарын 5нд батлагдсан халдварт өвчинтэй тэмцэх ба урьдчилан сэргийлэх хуулийн заалтын үндэслэлээр (234-р хуулийн 1570-р зүйл) эмчлэгдэх үүрэгтэй халдварт өвчин илэрсэн ба тэдгээр өвчнөөр өвчилсөн байж болох шинж тэмдэг илэрсэн боловч гадаадын иргэн эмчлүүлэхээс татгалзаж байгаа бол;

- ▲ улсын санд татвар төлөхөөс зайлсхийж байгаа бол

- ▲ Польш улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар байгаа бол;

3. өөр газар байнга оршин суурьшихаар Польш улсыг орхиж гарсан зэрэг шалтгаанууд орно.

#### **4.11 ГАДААДАД БАЙГАА НӨХЦӨЛД ТҮР ХУГАЦААГААР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ХӨӨЦӨЛДӨХ**

Польшийн хилээс гадна байгаа гадаадын иргэн түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдлийг амьдрах хүсэлтэй байгаа газарт нь харъяалагдах мужийн захиргаанд консулаар дамжуулан гаргана. Түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдлийг гаргахдаа маягт бөглөнө.

Хэрэв түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийн өргөдөлийг Польшийн хилийн гадна гаргасан бол мужийн захиргааны шийдвэр консулаар дамжин олгогдоно. Түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийн шийдвэрийг олгох явцад гадаадын иргэн Польшийн хилийн гадна байгаа бол Польшийн нутаг дэвсгэр дээр орж ирхийн тулд түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийг гаргуулах зорилгоор Шенгений виз хөөцөлдөх хэрэгтэй.

Оршин суух эрхийн карт нь Польш улсын нутаг дэвсгэр дээр орж ирсэнийх нь дараа түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийн шийдвэрийг гаргасан мужийн захиргаанаас олгодоно.

Гадаадын иргэн оршин суух эрхийн картгүйг заавал **өөрийн биеэр** ирж авна. Харин 13-с доош бага насны хүүхэд бол хуулиар заасан асрагч эсвэл хүүхдийн эрхийг хамгаалах албаны ажилтанд олгоно.

## БҮЛЭГ V

### БАЙНГА ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ

Байнга оршин суух зөвшөөрлийг дараах гадаадын иргэдэд олгоно. Үүнд:

1. хэрэв байнга оршин суух эрхтэй гадаадын иргэний Польш улсын нутаг дэвсгэр дээр **төрсөн бага насны хүүхэд бол;**
2. Польш улсын иргэнтэй гэр бүл болсон бөгөөд өргөдөл гаргахаас өмнө дор хаяж 3 жилийн өмнө гэрлэсэн, өргөдөл гаргахаас яг өмнө нь Польш улсын нутаг дэвсгэр дээр түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийн үндэслэлээр тасралтгүйгээр 2 жил амьдарсан;
3. 2003 оны 6 сарын 13-нд батлагдсан 2-р заалтын эсвэл 1-р заалтын 97-р бүлэгийн 1 ба 1а зүйлийн үндсэн дээр Польш улсын нутаг дэвсгэр дээр **хүлээн зөвшөөрсөн оршин суух эрхийн үндэслэлээр** тасралтгүйгээр дор хаяж **10 жилийн хугацаагаар** амьдарсан эсвэл **5 жилийн турш нэмэлт хамгаалалт буюу цагаачлалын статустайгаар** амьдарсан ;
4. Польшийн иргэний хүүхэд бөгөөд асран хамгаалалтанд нь байгаа бол орно.

#### 5.1 ШИЙДВЭР ГАРГАГЧ БАЙГУЛЛАГА

Байнга оршин суух зөвшөөрлийн шийдвэрийг гадаадын иргэний оршин суугаа харьяат газрын мужийн захиргаа гаргана. Байнга оршин суух зөвшөөрөл хүсэх өргөдлийг гаргахдаа өргөдлийн маягт бөглөнө.

#### 5.2 ТАСРАЛТГҮЙ АМЬДАРСАН БАЙХ ШААРДЛАГА – ЗӨВТГӨХ ШАЛТГААНТАЙ ЗАСВАРЛАГААНУУД

Польшид амьдрах хугацаанд гарсан завсарлага нэг бүр **6 сараас дээш, бүх завсарлага нийлээд 10 сараас дээш** хугацааг хэтрээгүй бол **тасралтгүй** амьдарсан гэж үзнэ.

Хэрэв дараах шалтгаанаар завсарлага гарсан бол дээрх нөхцөлд хамаарахгүй. Үүнд:

- Польшийн газар нутагт үйл ажиллагаагаа явуулдаг ажил олгогчийн гаргасан ажилын гэрээний үндэс дээр Польшийн газар нутагаас гадагшаа **ажилын томилолтоор явсан бол,**
- дээр дурьдсан шалтгаанаар гэр бүлийн хүн нь томилолтоор явахад **хамт явах шаардлагатай байсан бол,**
- эмчилгээнд **явах шаардлагатай** байсан зэрэг шалтгаанууд орно.

#### 5.3 БИЧИГ БАРИМТУУД

Гадаадын иргэн:

- Хүчинтэй **аялалын бичиг баримтаа** танилцуулах: Онцгой шалтгаанаар хэрэв гадаадын иргэн аялалын бичиг баримт байхгүй бөгөөд олж авах боломжгүй нөхцөлд **биеийн байцаалтыг нь нотлох өөр бичиг баримт үзүүлж болно;**
- өргөдөлийн маягтыг бөглөж, дараах зүйлсийг хавсаргах:

- **сүүлд авуулсан 4 хувь зураг** – урагдаж гэмтээгүй, сүүлийн 6 сарын дотор авуулсан, 35 х 45 мм хэмжээтэй ар талдаа цайвар дэвсгэртэй, хурц тод өнгийн зураг, нүд болон царайг тод харуулсан, толгойны оройноос мөр хүртэл биеийн хэсэг орсон **ба түүндээ нүүрний хэсэг зургийн 70-80% - ийг эзэлсэн** царайны энгийн байдал харуулсан, амаа жимийсэн, алчуур, болон хар нүдний шил зүүгээгүй.
- байнга оршин суух зөвшөөрөл хөөцөлдөх болсон тайлбар шалтгаан болон түүнд бичигдсэн мэдээллүүдийг батлах бичиг баримтууд
- **тэмдэгтийн хураамж төлсөн баримт**
- 1-р заалтын 64-р бүлгийн 3-р зүйлийг үндлэслэж байнга оршин суух зөвшөөрөл хөөцөлдөж буй тохиолдолд гадаад иргэний амьдарч байгаа ба амьдархаар зэхэж байгаа **байранд алба ёсоор бүртгэгдсэн гэсэн бичиг баримт**. Гадаад иргэний амьдарч байгаа ба амьдархаар зэхэж байгаа байранд **албан ёсоор бүртгэгдсэн гэсэн бичиг баримтад** байрандаа үнэгүй суулгах гэрээ ордоггүй ч хэрэв суулгаж байгаа хүн нь гэр бүлийн хүн хүүхэд ба ойрын хамаатан, хадам аав ээж бол хүчинтэйд тооцогдож болно.

#### 5.4 ӨРГӨДӨЛД ХАМААРАЛТАЙ НЭМЭЛТ ШААРДЛАГУУД

Гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр **хууль ёсоор амьдарч** байх үедээ байнга оршин суух зөвшөөрөл хөөцөлдөх боломжтой.

Хэрэв гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр хууль ёсоор амьдарч байх үедээ гаргасан ба бүх хүснэгт нь бөглөгдсөн, дутуу баримтыг хугацаанд хавсарган өргөдлийг мужийн ажилтан хүлээн авч байнга оршин суух зөвшөөрөл хөөцөлдөх өргөдөл гаргасныг баталгаажуулж аялалын бичиг баримт дээр нь **тамга дарна**.

Дээрхи бүх үйлдлийг гүйцэтгэсэн өдрөөс эхлэн байнга оршин суух зөвшөөрөл албан ёсоор гарах өдөр хүртэл гадаадын иргэнийг Польш улсын нутагт хууль ёсоор байгаа гэж үзнэ.

Байнга оршин суух зөвшөөрөл олгох **үйл явц** өргөдөл гаргагчийн хүсэлтээр **түр зогсоогдсон** бол тэр хугацаа нь **хууль ёсоор амьдарч байгаад тооцогдохгүй**.

#### АНХААР:

Гадаад паспорт дээр дарсан тамга нь тухайн хүнд Шенген-ий орноор аялах эрх олгохгүй, харин гадаадын иргэн өөрийн улсруу явахад чөлөөтэй.

#### 5.5 ӨРГӨДЛИЙГ ХАРГАЛЗАЖ ҮЗЭХГҮЙ ШАЛТГААН

Түр хугацаанд оршин суух зөвшөөрөл өгөх өргөдлийг дараах гадаадын иргэн гаргасан бол харгалзаж үзэхгүй:

- Польш улсын **хилийн гадна** байгаа;
- Польш улсын нутаг дэвсгэр дээр **хууль бусаар байгаа**;
- хүмүүнлэгийн асуудлаар ба улсын эрх ашигийг хамгаалах эсвэл олон улсын гэрээгээр орж ирсэн гадаад иргэдийн тухай хуулийн **1-р заалт 26-р зүйлд** дурдсаны дагуу зөвхөн Польш улсад орж ирэхэд хүчинтэй Шенгений визээр Польш улсын нутаг дэвсгэр дээр байгаа;

- гадаад иргэдийн талаарх хуулийн **2-р заалтын 53а бүлэгт** заасан үндэслэлээр түр хугацаагаар оршин суух зөвшөөрлөөр Польш улсын нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа ба Польш улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар амьдарч байгаа эсвэл
  - харуул хамгаалалттай газар албадан гаргах зорилгоор хоригдсон байгаа ба тухайн гадаадын иргэнийг нутаг дэвсгэрээсээ гаргах шийд гаргасан эсвэл хуулийн дагуу арга хэмжээ авхуулан хоригдсон;
- болон
- **өргөдөл бөглөх зааварчилгааг сахихгүй бол.** Үүнд:
    - өргөдлийн хүснэгт болгоныг бөглөөгүй бол;
    - аялалын бичиг баримт байхгүй бол, онцгой шалтгаантай үед – биеийн байцаалтыг батлах өөр бичиг баримтыг харуулаагүй бол;
    - өргөдөлд:
      - **сүүлийн үед авуулсан 4 хувь зураг**
      - шаардлагатай нөхцөлд амьдрах байрандаа албан ёсоор бүртгэгдсэн зэрэг бичиг баримтыг хавсаргаагүй бол.

#### **5.6 БАЙНГА ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ**

Дараах шалтгаанаар гадаадын иргэнд түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийг өгөхөөс татгалзаж болно. Үүнд:

1. **1-р заалтын 64-р бүлэгт** дурдсан шаардлагыг биелүүлэхгүй байгаа;
2. Польш улс өөрийн нутагтаа амьдруулах хүсэлгүй байгаа гадаадын иргэдийн жагсаалтанд гадаадын иргэн бичигдсэн бол;
3. Шенгений бусад орон газар нутагтаа оруулахаас татгалзсан шалтгаанаар тухайн иргэний нэр овог Шенгений Мэдээллийн Системд бичигдсэн бол;
4. зөвшөөрөл олгох нь Польш улсын ашиг сонирхол, аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд нийцэхгүй тохиолдолд;
5. Польшийн иргэнтэй гэр бүл болсоны үндсэн дээр зөвшөөрөл хөөцөлдөж байгаа бөгөөд түр хугацаагаар оршин суух ба байнга оршин суух зөвшөөрлийг авах хууль дүрмийг тойрч гарах зорилгоор гэр бүл болсон бол;
6. байнга оршин суух зөвшөөрөл өгөх үйл явцын дунд:
  - а) өргөдөлд ташаа мэдээлэл өгсөн эсвэл хуурамч нэр овог мэдээлэл агуулсан бичиг баримт хавсаргасан;
  - б) худал мэдүүлэлт өгсөн ба үнэнийг нуусан эсвэл бичиг баримтыг хуурамчаар үйлдэж түүнийгээ жинхэнэ баримт бичиг шиг ашигласан;
7. Улсын санд татвар төлөх үүргээс зайлсхийж байгаа бол;
8. улсын төсвөөс санхүүжүүлэх албадан гаргах зардалыг нөхөн төлөөгүй бол;

#### **5.7 БАЙНГА ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙГ БУЦААЖ ТАТАН АВАХ**

Гадаад иргэний байнга оршин суух зөвшөөрлийг дараах шалтгаанаар буцаан татан авч болно. Үүнд:

- 1) зөвшөөрөл олгох нь Польш улсын ашиг сонирхол, аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд нийцэхгүй тохиолдолд;
- 2) өргөдөлд ташаа мэдээлэл өгсөн эсвэл хуурамч нэр овог мэдээлэл агуулсан бичиг баримт хавсаргасан;
- 3) Түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл өгөх үйл явцын дунд худал мэдүүллэг өгсөн ба үнэнийг нуусан эсвэл бичиг баримтыг хуурамчаар үйлдэж түүнийгээ жинхэнэ баримт бичиг шиг ашигласан;
- 4) санаатайгаар гэмт хэрэг үйлдсэний үндсэн дээр Польш улсын хуулиар дор хаяж 3 жилийн хоригдох ялаар шийтгүүлсэн бол;
- 5) өөр газар байнга оршин суурьшихаар Польш улсыг орхиж гарсан зэрэг шалтгаанууд орно.

#### **5.8 БАЙНГА ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ ХУГАЦАА**

Байнга оршин суух зөвшөөрлийг **хугацаагүйгээр** олгоно. Байнга оршин суух зөвшөөрөл авсаныг батлах бичиг баримт нь 10 жилээр гардаг оршин суух эрхийн карт юм. Европын Холбоонд удаан хугацаагаар оршин суух эрх авсан тэр өдрөөс байнгын оршин суух зөвшөөрөл хуулиар хүчингүй болно.



## БҮЛЭГ VI

### ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСАД УДААН ХУГАЦААГААР АМЬДРАХ ЗӨВШӨӨРӨЛ

Европын Холбооны Улсад удаан хугацаагаар амьдрах зөвшөөрлийг өргөдөл гаргахаас яг өмнө дор хаяж 5 жилийн хугацаагаар хууль ёсоор тасратгүйгээр Польш улсын нутагт дэвсгэр дээр амьдарч байгаа гадаадын иргэн дараах баталгааг гаргаж чадсан тохиолдолд олгоно. Үүнд:

- өөрийн болон гэр бүлийн гишүүдийн амьдрах зардлыг нөхөж чадахуйц **байнгын тогтмол орлогын эх үүсвэртэй**;
- **эрүүл мэндийн даатгалд хамрагдсан**, үүнийг ойлгохдоо нийтийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсвэл Польш улсын нутаг дэвсгэр дээр эмчилгээ хийх зардлыг хариуцана гэсэн даатгагчийн баталгаа

#### 6.1 ШИЙДВЭР ГАРГАГЧ БАЙГУУЛЛАГА

Европын Холбооны Улсад удаан хугацаагаар амьдрах зөвшөөрлийн шийдвэрийг гадаадын иргэний оршин суугаа харьяат газрын мужийн захиргаа гаргана. Европын Холбооны Улсад удаан хугацаагаар амьдрах зөвшөөрөл хүсэх өргөдлийг гаргахдаа өргөдлийн маягт бөглөнө.

#### 6.2 БИЧИГ БАРИМТУУД

Гадаадын иргэн:

- Хүчинтэй **аялалын бичиг баримтаа** танилцуулах: Онцгой шалтгаанаар хэрэв гадаадын иргэн аялалын бичиг баримт байхгүй бөгөөд олж авах боломжгүй нөхцөлд биеийн байцаалтыг нь нотлох өөр бичиг баримт үзүүлж болно;
- **өргөдөлийн маягтыг бөглөж**, дараах зүйлсийг хавсаргах:
  - **сүүлд авуулсан 4 хувь зураг** – урагдаж гэмтээгүй, сүүлийн 6 сарын дотор авуулсан, 35 x 45 мм хэмжээтэй ар талдаа цайвар дэвсгэртэй, хурц тод өнгийн зураг, нүд болон царайг тод харуулсан, толгойны оройноос мөр хүртэл биеийн хэсэг орсон ба царайны хэсэг 70-80%-г эзэлсэн, царайны энгийн байдал харуулсан, амаа жимийсэн, алчуур, болон хар нүдний шил зүүгээгүй.
  - Европын Холбооны Улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл хөөцөлдөх болсон тайлбар шалтгаан болон түүнд **бичигдсэн мэдээллүүдийг батлах бичиг баримтууд**
  - **тэмдэгтийн хураамж төлсөн баримт**
  - 1-р заалтын 64-р байр бүлгийн 3-р зүйлийг үндэслэж байнга оршин суух зөвшөөрөл хөөцөлдөж буй тохиолдолд гадаад иргэний амьдарч байгаа ба амьдархаар зэхэж байгаа **байранд албан ёсоор бүртгэгдсэн гэсэн бичиг баримт**. Гадаад иргэний амьдарч байгаа ба амьдархаар зэхэж байгаа **байранд албан ёсоор бүртгэгдсэн гэсэн бичиг баримтад** байрандаа **үнэгүйгээр суулгах гэрээ ордоггүй** ч хэрэв суулгаж байгаа хүн нь гэр бүлийн хүн хүүхэд ба ойрын хамаатан, хадам аав ээж бол хүчинтэйд тооцогдож болно.

### 6.3 ӨРГӨДӨЛД ХАМААРАЛТАЙ НЭМЭЛТ ШААРДЛАГУУД

Гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр хууль ёсоор амьдарч байх үедээ Европын Холбооны Улсад удаан хугацаагаар амьдрах зөвшөөрөл хөөцөлдөх боломжтой.

Хэрэв гадаадын иргэн Польш улсын нутаг дэвсгэр дээр хууль ёсоор амьдарч байх үедээ гаргасан ба бүх хүснэгт нь бөглөгдсөн, дутуу баримтыг хугацаанд хавсаргасан өргөдлийг мужийн ажилтан хүлээн авч байнга оршин суух зөвшөөрөл хөөцөлдөх өргөдөл гаргасныг баталгаажуулж аялалын бичиг баримт дээр нь **тамга дарна**.

Дээрхи бүх үйлдлийг гүйцэтгэсэн өдрөөс эхлэн Европын Холбооны улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл албан ёсоор гарах өдөр хүртэл гадаадын иргэнийг Польш улсын нутагт хууль ёсоор байгаа гэж үзнэ.

Европын Холбооны улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгох **үйл явц өргөдөл гаргагчийн хүсэлтээр түр зогсоогдсон** бол тэр хугацаа нь **хууль ёсоор амьдарч байгаад тооцогдохгүй**.

#### АНХААР:

Гадаад паспорт дээр дарсан тамга нь тухайн хүнд Шенгений бусад орноор аялах эрх олгохгүй, харин гадаадын иргэн өөрийн улсруу явахад чөлөөтэй.

### 6.4 ӨРГӨДЛИЙГ ХАРГАЛЗАЖ ҮЗЭХГҮЙ ШАЛТГААН

Гадаадын иргэнд Европын Холбооны улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл өгөх өргөдлийг дараах шалтгаанаар харгалзаж үзэхгүй:

- Польш улсын хилийн гадна байгаа;
- Польш улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар байгаа;
- хүмүүнлэгийн асуудлаар ба улсын эрх ашигийг хамгаалах эсвэл олон улсын гэрээгээр орж ирсэн гадаад иргэдийн тухай хуулийн **1-р заалт 26-р зүйлд** дурдсаны дагуу зөвхөн Польш улсад орж ирэхэд хүчинтэй Шенгений визээр Польш улсын нутаг дэвсгэр дээр байгаа;
- Гадаад иргэдийн талаарх хуулийн **2-р заалтын 53а бүлэгт** заасан үндэслэлээр түр хугацаагаар оршин суух зөвшөөрлөөр Польш улсын улсын нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа, Польш улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар амьдарч байгаа тохиолдолд, эсвэл
- **Харуул хамгаалалттай газар** албадан гаргах зорилгоор хоригдсон байгаа ба тухайн гадаадын иргэнийг нутаг дэвсгэрээсээ гаргах шийд гаргасан эсвэл хуулийн дагуу арга хэмжээ авхуулан хоригдсон;
- Польш улсын нутаг дэвсгэр дээр **мэргэжилийн сургалт, дээд сургуульд сурах зорилгоор байгаа;**
- Польш улсын нутаг дэвсгэр дээр амьдрахыг хүлээн зөвшөөрсөн, хорогдох зөвшөөрөл олгосон, цагаачлах эрх авсан эсвэл нэмэлт болон түр хугацаагаар хамгаалалтанд байгаа,
- **Хорогдох зөвшөөрөл ба цагаачлах эрх хөөцөлдөж байгаа,**

- “aupair”-ын ажилтан, улирлын чанартай ажил эрхлэгч, хил дамжин үйлчилгээ үзүүлэгч эсвэл түүний томилолтоор хил дамжин үйлчилгээ хийж байгаа ажилтан, болон
- Гадаад иргэдийн тухай хуулийн **1-р заалтын 53-р бүлгийн 5 эсвэл 7-р зүйл, 1-р заалтын 53а бүлгийн 1-р зүйлийн** үндэслэлээр Польш улсын нутаг дэвсгэр дээр түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл авсаны үндсэн дээр амьдарч байгаа, Болон
- **Өргөдөл бөглөх зааварчилгааг сахиагүй бол.** Үүнд:
  - өргөдлийн хүснэгт болгоныг бөглөөгүй бол,
  - аялалын бичиг баримт байхгүй бол, онцгой шалтгаантай үед-биеийн байцаалтыг батлах өөр бичиг баримтыг харуулаагүй бол,
  - өргөдөлд:
    - сүүлийн үед авуулсан 4 хувь зураг
    - амьдрах байрандаа албан ёсоор бүртгэгдсэн зэрэг бичиг баримтыг хавсаргаагүй бол.

#### **6.5 ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСАД УДААН ХУГАЦААГААР АМЬДРАХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ БОЛОМЖГҮЙ ХҮМҮҮС**

Европын Холбооны Улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлийг дараахи гадаадын иргэдэд олгох боломжгүй:

1. Польш улсын нутаг дэвсгэр дээр сурч боловсорч байгаа эсвэл мэргэжил дээшлүүлэх сургалтад оролцох зорилгоор амьдарч байгаа бол;
2. Польш улсын нутаг дэвсгэр дээр амьдрахыг хүлээн зөвшөөрсөн, хорогдох зөвшөөрөл олгосон, цагаачлах эрх авсан эсвэл түр хугацаагаар хамгаалалтанд байгаа бол;
3. хорогдох зөвшөөрөл ба цагаачлах эрх хөөцөлдөж байгаа бол;
4. “aupair”-ын ажилтан, улирлын чанартай ажил эрхлэгч, хил дамжин үйлчилгээ үзүүлэгч эсвэл түүний томилолтоор хил дамжин үйлчилгээ хийж байгаа ажилтан;
5. **1-р заалтын 26-р бүлгийн 26-р зүйлд** дурдсаны дагуу Польш улсын нутаг дэвсгэр дээр орж ирэх ба амьдрах зорилгоор Шенген-ий визийн үндэслэлээр байгаа эсвэл гадаад иргэдийн тухай хуулийн **1-р заалтын 53-р бүлгийн 5 эсвэл 7-р зүйл, 2-р заалтын 53а бүлгийн 1-р зүйлийн** үндэслэлээр Польш улсын нутаг дэвсгэр дээр түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл авсаны үндсэн дээр амьдарч байгаа бол;
6. харуул хамгаалалттай газар албадан гаргах зорилгоор хоригдсон байгаа ба тухайн гадаадын иргэний эсрэг арга хэмжээ авагдаж нутаг дэвсгэрээсээ гарч явахыг хориглосон шийд гаргасан эсвэл хуулиар гаргасан шийдвэрийн үндэслэлээр хоригдсон зэрэг болно.

#### **6.6 ХУУЛЬ ЁСООР ТАСРАЛТГҮЙ 5 ЖИЛ ОРШИН СУУХ ШААРДЛАГА**

Европын Холбооны Улсад удаан хугацаагаар амьдрах зөвшөөрөл олгоход шаардлагатай **5 жил оршин суусан хугацаанд** дараах шалтгаанаар оршин сууж байгаа гадаад иргэний амьдарч байгаа хугацаа орохгүй:

1. **харуул хамгаалалттай газар** албадан гаргах зорилгоор хоригдсон байгаа ба тухайн гадаадын иргэний эсрэг арга хэмжээ авагдаж нутаг дэвсгэрээсээ гарч явахыг хориглосон шийд гаргасан эсвэл хуулиар гаргасан шийдвэрийн үндэслэлээр хоригдсон;
2. **“aupair”** –ийн ажилтан, улирлын чанартай ажил эрхлэгч, хил дамжин үйлчилгээ үзүүлэгч эсвэл түүний томилолтоор хил дамжин үйлчилгээ хийж байгаа;
3. **1-р заалтын 26-р бүлгийн 26-р зүйлд** дурдсаны дагуу Польш улсын нутаг дэвсгэр дээр орж ирэх ба амьдрах зорилгоор Шенген-ий визийн үндэслэлээр байгаа эсвэл гадаад иргэдийн тухай хуулийн **1-р заалтын 53-р бүлгийн 5 эсвэл 7-р зүйл, 2-р заалтын 53а бүлгийн 1-р зүйлийн** үндэслэлээр Польш улсын нутаг дэвсгэр дээр түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл авсаны үндсэн дээр амьдарч байгаа бол;
4. **Дипломат аяны гишүүн ажилтан, дарга**, гадаад орны консулын газрын дарга ба ажилтнууд болон тэдэнтэй жишихээр олон улсын харилцааны үүрэгтэй гэрээ хэлэлцээртэй хүмүүс.

**Европын Холбооны Улсад удаан хугацаагаар амьдрах зөвшөөрөл олгоход шаардлагатай 5 жил оршин суусан хугацаанд дараах шалтгаанаар оршин сууж байгаа иргэний оршин суусан хугацааны талыг оруулж болно:**

1. **Мэргэжил дээшлүүлэх сургалт, эсвэл их сургуульд сурахтай** холбоотойгоор виз олгосон буюу
2. Гадаадын иргэдийн тухай хуулийн **1-р заалтын 53-р бүлгийн 16-р зүйл, эсвэл 1-р заалтын 53а бүлгийн 1-р зүйлийн** (их сургууль ба мэргэжлийн сургалт) үндэслэлээр Польш улсын нутаг дэвсгэр дээр түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл авсаны үндсэн дээр амьдарч байгаа бол.

#### **6.7 ТАСРАЛТГҮЙ ОРШИН СУУХ ШААРДЛАГА- ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН ЗАВСАРУУД**

Польшид амьдрах хугацаанд гарсан завсар **6 сараас дээш, бүхэлдээ нийлээд 10 сараас дээш хугацааг хэтрээгүй** бол тасралтгүй амьдарсан гэж үзнэ.

Хэрэв дараах шалтгаанаар завсарлага гарсан бол дээрх нөхцөлд хамаарахгүй. Үүнд:

- Польшийн газар нутагт үйл ажиллагаагаа явуулдаг ажил олгогчийн гаргасан ажилын гэрээний үндэс дээр Польшийн газар нутагаас гадагшаа **ажилын томилолтоор явсан бол,**
- дээр дурьдсан шалтгаанаар гэр бүлийн хүн нь томилолтоор явахад **хамт явах шаардлагатай байсан бол,**

- **эмчилгээнд явах шаардлагатай байсан** зэрэг шалтгаанууд орно.

#### **6.8 ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСАД УДААН ХУГАЦААГААР АМЬДРАХ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ**

- 1.1-р заалтын 65-р бүлэгт дурдсан шаардлагыг биелүүлэхгүй байгаа;
2. зөвшөөрөл олгох нь Польш улсын ашиг сонирхол, **аюулгүй байдал**, нийтийн дэг журам ба аюулгүй байдалд нийцэхгүй тохиолдолд;

#### **6.9 ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСАД УДААН ХУГАЦААГААР АМЬДРАХ ЗӨВШӨӨРЛИЙГ БУЦААН ТАТАЖ АВАХ**

Гадаадын иргэнд олгосон Европын Холбооны Улсад удаан хугацаагаар амьдрах зөвшөөрлийг татан авах шалтгаанд:

1. Европын Холбооны Улсад удаан хугацаагаар амьдрах зөвшөөрлийг хууль бусаар олж авсан бол
2. Польш улсын ашиг сонирхол, аюулгүй байдал, нийтийн дэг журам ба аюулгүй байдалд аюул учруулахаар бол;
3. Польш улсын нутаг дэвсгэрийг 6-с дээш жилээр орхиж гарсан бол;
4. Европын Холбооны нутаг дэвсгэрийг дараалсан 12 сарын хугацаагаар орхиж гарсан бол;
5. Европын холбооны гишүүн өөр улсын нутаг дэвсгэр дээр удаан хугацаагаар оршин суух эрх авсан зэрэг орно.

#### **6.10 ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСАД УДААН ХУГАЦААГААР АМЬДРАХ ЗӨВШӨӨРЛИЙГ ДАХИН ОЛЖ АВАХ**

Гадаадын иргэнд олгосон Европын Холбооны Улсад удаан хугацаагаар амьдрах зөвшөөрлийг гадаадын иргэдийн тухай хуулийн 1-р заалтын 69-р бүлэг 3-5-р зүйлд дурдсан шалтгаанаар татан авсан тохиолдолд Европын Холбооны Улсад удаан хугацаагаар амьдрах дараагийн зөвшөөрлийг гадаадын иргэн 65-р бүлэгт бичигдсэн нөхцлүүдийг биелүүлж байгаа бөгөөд дахин зөвшөөрөл олгох өргөдөл гаргахаас яг өмнө нь Польш улсын газар нутаг дээр хууль ёсоор тасралтгүйгээр дор хаяж 3 жил амьдарсан байх ёстой.

#### **6.11 ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСАД УДААН ХУГАЦААГААР АМЬДРАХ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ ХУГАЦАА**

Европын Холбооны Улсад удаан хугацаагаар амьдрах зөвшөөрлийг хугацаагүйгээр олгоно. Европын Холбооны Улсад удаан хугацаагаар амьдрах зөвшөөрөл авсаныг батлах бичиг баримт нь 5 жилээр гардаг оршин суух эрхийн карт юм. Европын Холбооны Улсад удаан хугацаагаар оршуйн суух эрх авсан тэр өдрөөс байнгын оршин суух зөвшөөрөл хуулиар хүчингүй болно.

## БҮЛЭГ VII

### ОРШИН СУУХ ЭРХИЙН КАРТ

#### 7.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Гадаадын иргэн:

- ▲ түр хугацаагаар оршин суух
- ▲ байнга оршин суух
- ▲ Европын Холбооны улсад удаан хугацаагаар оршин суух зэрэг зөвшөөрлийг авсан бол оршин суух эрхийн карт олгоно.

**Оршин суух эрхийн карт нь** хүчинтэй үедээ гадаадын иргэний Польш улсад амьдрах хугацааны биеийн байцаалтын баталгаа болох бөгөөд **аялан жуулчлах баримт бичигийн хамт** Польш улсын хилээр визгүй олон удаа орж гарах эрхийг олгоно.

2 сараас дээш хугацаанд амьдарсан хаягийн бүртгэл байхгүй нөхцөлд оршин суух эрхийн карт дээр тухайн хүний хаяг бичигдэхгүй.

Түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийн шийдвэрийг олгох явцад гадаадын иргэн Польшийн хилийн гадна байгаа бол Польшийн нутаг дэвсгэр дээр орж ирхийн тулд түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийг хэрэгжүүлэх зорилгоор Шенген-ий виз хөөцөлдөх хэрэгтэй.

Оршин суух эрхийн карт нь Польш улсын нутаг дэвсгэр дээр орж ирсэнийх нь дараа түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийг гаргасан мужийн захиргаанаас олгогдоно.

Гадаадын иргэн оршин суух эрхийн картыг заавал **өөрийн биеэр** ирж авна.

13-с доош бага насны хүүхэд бол хуулиар заасан асрагч эсвэл хүүхдийн эрхийг хамгаалах албаны ажилтанд олгоно.

**Оршин суух картыг авахдаа 50 золотын төлбөр төлнө. Энэ төлбөрийг тухайн мужийн захиргааны дансанд хийнэ.**

#### 7.2 ОРШИН СУУХ ЭРХИЙН КАРТИЙГ СОЛИХ

Гадаадын иргэн дараах тохиолдолд **оршин суух картаа солих** шаардлагатай. Үүнд:

- 1) картад бичигдсэн мэдээлэлд өөрчлөлт орсон;
- 2) биеийн байцаалт явуулахад хүндрэл учруулж болохоор элэгдсэн;
- 3) ашиглахад хэцүүгээр урагдаж гэмтсэн;
- 4) алга болсон буюу гэмтсэн;
- 5) байнга оршин суух эсвэл Европын Холбооны улсад байнга оршин суух зөвшөөрөлтөйгөөр олгосон оршин суух картын хугацаа дууссан зэрэг болно.

### 7.3 ОРШИН СУУХ ЭРХИЙН КАРТИЙГ СОЛЬЖ ӨГӨХ БАЙГУУЛЛАГА

Гадаадын иргэний амьдарч байгаа харъяа газрын мужийн захиргаа оршин суух эрхийн картийг сольж өгөх эрхтэй. Оршин суух эрхийн картыг авах болон солиход **төлбөр** төлөх шаардлагатай.

Картийг солих **өргөдлийг** гаргахдаа тусгай маягт бөглөдөг. Картаа солихыг хүсэж байгаа гадаадын иргэн **хүчинтэй аялалын бичиг баримтаа харуулахын хамт дараах зүйлсийг өргөдөлдөө хавсаргах ёстой**. Үүнд:

- 1) өргөдөлд хамрах хүмүүсийн зураг, заасан хэмжээний дагуу авхуулсан
- 2) өргөдөлд заасан мэдээллүүдийг батлах бичиг баримт орно.

Оршин суух эрхийн картаа солиулах гэж байгаа гадаадын иргэн онцгой шалтгаанаар аялалын бичиг баримт байхгүй бөгөөд олж авах боломжгүй нөхцөлд **биеийн байцаалтыг нь нотлох өөр бичиг баримт үзүүлж болно**.

### 7.4 ОРШИН СУУХ ЭРХИЙН КАРТИЙГ ГЭЭЖ ҮРЭГДҮҮЛЭХ

**Оршин суух эрхийн картаа гээж үрэгдүүлсэн** тохиолдолд тухайн гадаадын иргэн гээж үрэгдүүлсэн өдрөөс **3 хоногийн дотор** энэ талаар карт-ыг олгосон **мужийн захиргаанд** мэдэгдэх үүрэгтэй. Гээгдсэн карт-ыг олсон тохиолдолд олдсон өдрөөс 3 хоногийн дотор мужийн захиргаанд мэдэгдэх ба хэрэв шинээр карт олгогдсон бол гээгдсэн байсан картийг олгосон байгууллагад нь буцааж өгөх үүрэгтэй.

**Польшийн иргэн болсоныг** батлах бичиг баримт авсан, эсвэл түр хугацаагаар оршин суух, байнга оршин суух ба Европын Холбооны улсад байнга оршин суух зөвшөөрөлийг нь буцаан татаж авсан нөхцөлд гадаадын иргэн **оршин суух эрхийн картыг** олгосон байгууллагад нь **яаралтай буцааж өгөх үүрэгтэй**.

### 7.5 ОРШИН СУУХ ЭРХИЙН КАРТИЙГ АШИГЛАН АЯЛАН ЖУУЛЧЛАХ

Гадаадын иргэн **Польшид олгосон оршин суух эрхийн карт болон Шенгений бүсийн өөр нэг оронд олгосон зөвшөөрлийн үндэслэлээр Шенгений бүсийн орнуудаар** (Польш улсын нутаг дэвсгэр дээр мөн адил) **6 сарын дотор 3 сарын хугацааг хэтрүүлэлгүйгээр заавал виз авах шаардлагагүйгээр аялан жуулчилж болно**. Ингэхдээ Шенгений бусад орнуудад нэвтрэх ба амьдрах ерөнхий зарчмыг дагах хэрэгтэй. Үүнд:

- **хүчинтэй аялалын бичиг баримттай байх,**
- **байх хугацааныхаа нөхцөл, зорилгыг тайлбарлах чадвартай байх,**
- амьдрах хугацаандаа хэрэглэхэд **хангалттай санхүүгийн боломжтой**, эсвэл хууль ёсоор мөнгө олох боломжтой байх,
- **нийтийн аюулгүй байдал**, дотоодын хамгаалал, нийтийн эрүүл мэнд эсвэл гишүүн орнуудын олон улсын харилцаанд **аюул учруулахаар хүнд тооцогдоогүй байх,**

ялангуяа гишүүн орнуудын аль нэг оронд орох эрхээ хаалгаагүй байх гэх зэрэг болно.

**Шенген-ий бүсийн орнуудад: Австри, Белги, Дани, Финланд, Франц, Грек, Испани, Люксембург, Нидерланд, Герман, Португали, Швед, Итали, Естони, Литв, Латив, Малта, Польш, Словак, Словен, Унгар болон Норвег, Исланд ба Швейцарь орно.**(сүүлийн 3 орон Европын Холбооны улс биш ч Шенгений бүсэд хамрагддаг)

**Их Британи, Ирланд, Ципр, Болгар болон Румуни зэрэг орон Европын Холбооны улс ч Шенгений бүсийн орнуудад хамрагддаггүй анхаарна уу.**



## БҮЛЭГ VIII

### ДАВЖ ЗААЛДАХ ҮЙЛ ЯВЦ

Түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл/байнга оршин суух зөвшөөрөл/Европын Холбооны улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл/виза сунгах/оршин суух эрхийн картыг солих зэрэг асуудлаар мужийн захиргааны шийдвэрт гомдолтой байгаа бол **шийдвэр авсанаас хойш 14 хоногийн дотор** дээд шатны байгууллага болох **Гадаадын Иргэдийн Асуудал Хариуцах Газрын Даргад** давж заалдах эрхтэй байдаг.

**Давж заалдах бичигийг Гадаадын Иргэдийн Асуудал Хариуцах Газрын Удирдлагад тухайн шийдвэрийг гаргасан мужийн захиргаагаар дамжуулж гаргана.** Давж заалдах бичиг дээр гаргагч тал **гарын үсгээ** зурна.

**Давж заалдах үйл явцад Ерөнхий Мөрдлөгийг баримтлана. (2-р бүлэгийг үз)**

#### 8.1 ЗААСАН ХУГАЦАА БАГАДАХ

Давж заалдах хугацаа богинодох тохиолдолд хугацаа багадсан шалтгаантай нөхцөл дууссанаас **7 хоногийн дотор** дахин хугацаа хүсэх эрхтэй. Ингэхдээ **тухайн учир шалтгаан нь түүний буруугаас биш байсан гэдэгийг харуулах үүрэгтэй.**

**Хүсэлт гаргахийн хамт давж заалдах хэрэгтэй.**

#### 8.2 ХАВТАСТ ХЭРЭГТЭЙ ТАНИЛЦАХ

Цуглуулсан нотлох баримттай танилцах хүсэлтэй байгаа тохиолдолд өргөдөл гаргагч эсвэл түүний итгэмжлэгч нь энэ хүсэлтээ Гадаадын Иргэдийн Хууль ёсоор Оршин суух Асуудлыг Хариуцагч Байгууллагын Гомдол шийдвэрлэх Тасгийн нарийн бичигтэй **(22) 601 75 14** дугаарын **утсаар холбоо тогтоож** хэзээ Гадаадын Иргэдийн Асуудал Хариуцсан Байгууллагын үйлчлүүлэгчидтэй харилцах байранд очиж болох хугацааг тохирно. Энэ үйлчлүүлэгчидтэй харилцах байр нь **Варшав хотын Таборова гудамжны 33** номерт оршино.

**Мэдээллийг утсаар 3 дах өдрөөс бусад ажилын өдрүүдэд 10.00 – 15.00 цагийн хооронд авч болно.**

#### 8.3 МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАР, ӨРГӨДӨЛ, БИЧИГ БАРИМТЫГ ТУШААХ НЬ

**ТУШААХ БИЧИГ БАРИМТ НЬ ДАРААХ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙНА:**

- **эх хувиараа эсвэл албан ёсоор баталгаажуулсан хуулбар байх, Гадаадын иргэн бичиг баримтын эх хувийг харуулсаны үндсэн дээр хуулбарыг нь баталгаажуулах хүсэлтэй бол 00- 564 Варшав хотын Кошикова гудамжны 16-д байдаг Гадаад Иргэдийн Асуудал Хариуцсан Байгууллагын Дамжуулах албад хандаж болно.** Ажиллах цагийн хуваарь нь 8.15 – 16.00.

▲ тамгатай польш орчуулагчаар польш хэл дээр орчуулагдсан байх зэрэг болно. **Бичиг баримт (мэдэгдэл, тайлбар, өргөдөл)-ийг мөн дараахи шугамаар гаргаж болно. Үүнд:**

- **Шуудангийн харилцагчаар дамжуулж энэ хаягаар: 00-564 Варшав, Кошикова гудамж 16 тоот ;**
- **Гадаад иргэдийн асуудал хариуцсан Байгууллагын Дамжуулах алба: 00-564 Варшав, Кошикова гудамж 16 тоот, цагийн хуваарь 8.15-16.00**

#### **8.4 САНАЛ ГОМДОЛ**

Өргөдөл гаргагч тал нь Гадаадын Иргэдийн Асуудал Хариуцах Газрын Удирдлагын шийдвэрийг авсанаас 30 хоногийн дотор **санал гомдолоо Варшав хотын Мужийн Захиргааны Шүүхэд** гаргах эрхтэй. **Өргөдөл гаргагч тал санал гомдолоо Гадаадын Иргэдийн Асуудал Хариуцах Газрын Удирдлагаар дамжуулж гаргана.**

Эцсийн шийдвэрийн талаар Варшав хотын Мужийн Захиргааны Шүүхэд санал гомдол гаргаснаар гадаадын иргэний Польшийн нутаг дэвсгэр дээр оршин суух эрх хууль ёсны болохгүй.

## Мэдэгдэл

*Зааварчилгааг ..... хэл дээр хүлээн авсан.*

.....  
(он сар, газар) (өргөдөл гаргагч эсвэл хуулийн төлөөлөгчийн гарын үсэг)

.....(орчуулагчийн гарын үсэг)